

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2021 ОН

МӨРӨН

СУДАЛГААГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ХЭСЭГ

Багийн ахлагч:

Ц.Гончиг- ХХҮГ-ын Дэд дарга

Багийн гишүүд:

- | | |
|---------------|---|
| Б.Мөнхжаргал | - ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга |
| Т.Раднаабүд | - ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга |
| Н.Дэлгэрмөрөн | - ХХҮГ-ын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга |
| Ч.Алтанцоож | - ХХҮГ-ын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан
ахлах мэргэжилтэн |
| Б.Гантуяа | - ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн
ахлах мэргэжилтэн |
| Б.Мөнхтуяа | - ХХҮГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
ахлах мэргэжилтэн |
| Б.Баасанжав | -ХХҮГ-ын Программ хангамж, мэдээллийн технологи
хариуцсан мэргэжилтэн |
| Г.Цогбаяр | - ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл
хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн |
| Д.Оюунчимэг | - ХХҮГ-ын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн
аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| М.Батчимэг | - ХХҮГ-ын Ажил мэргэжлийн чиг баримжаа ажил
зуучлал хариуцсан мэргэжилтэн |
| Б.Энхбаяр | - ХХҮГ-ын Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны
шилжилт хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн |
| Д.Цэрэнчимэг | - ХХҮГ-ын гэрээт судлаач |

ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумдын
мэргэжилтнүүд

Сумдад ажилласан дэд ажлын хэсгийн гишүүд

Энэхүү судалгааг Швейцарийн хөгжлийн агентлаг, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг
дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр хийж гүйцэтгэв.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ ӨМНӨХ ҮГ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ГРАФИКИЙН ЖАГСААЛТ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ: ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ

- 1.1 Хүн амын ерөнхий мэдээлэл
- 1.2 Өрхийн ерөнхий мэдээлэл
- 1.3 Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн өнөөгийн байдал
- 1.4 Ажиллах хүчний төлөв байдал
- 1.5 Ажиллах хүчнээс гадуурх хүн амын төлөв байдал
- 1.6 Сурагчдын дунд хийсэн судалгааны үр дүн
- 1.7 Оюутнуудын дунд хийсэн судалгааны үр дүн
- 1.8 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч, төгсөгчдийн дунд хийсэн судалгааны үр дүн
- 1.9 Ажилгүй иргэдийн дунд хийсэн судалгааны үр дүн

ХОЁР: ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ

- 2.1 Ажил олгогчдын ерөнхий мэдээлэл
- 2.2 Ажил олгогчдын дунд хийсэн судалгааны үр дүн
- 2.3 Ажлын байрны зард хийсэн дүн шинжилгээ
- 2.4 Төрийн албан хаагчдын тоон мэдээ
- 2.5 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд хийсэн судалгааны үр дүн
- 2.6 Малчдын дунд хийсэн судалгааны үр дүн

ГУРАВ: ДҮГНЭЛТ

ДӨРӨВ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ТАВ: ХАВСРАЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн бүдүүвч /23 сум/
Их, дээд сургуульд суралцаж буй оюутнууд мэргэжил, курсээр /23 сум/
Ашигласан материал, ном зүй
Үндсэн ойлголтын тайлбар



ТАЛАРХАЛ

Аливаа бодлого хөтөлбөр, үйл ажиллагаа, арга хэмжээ амжилттай хэрэгжих, эерэг үр дүн өгөх эсэх нь тухайн асуудлыг хэр шинжлэх ухаанч байдлаар судалсан, нөхцөл байдлыг хэрхэн зөв дүгнэснээс шалтгаалдаг билээ.

Миний бие аймгийн Засаг даргын хувьд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийнхөө зүйл заалт, үйл ажиллагаа, арга хэмжээ бүхэнд судалгааны үндэс суурьтай хандаж, тухайн салбарын статистик мэдээлэл, судлаачдын өгсөн санал дүгнэлтэд тулгуурлан шууд удирдлагын болон эрхлэх хүрээний төрийн байгууллагуудыг удирдлагаар ханган ажиллаж, үр дүн гаргахыг зорьж байгаа.

Хөдөлмөрийн салбар бол хүн амын эрүүл мэнд, боловсролын салбартай эн тэнцэхүйц чухал, том салбар. Тиймээс Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг судлах цаашлаад ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчийг өргөтгөх талаар зорилт, арга хэмжээг тусган ажиллаж байна.

Үндсэн чиглэл болон үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжиж эхэлж буй энэ онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас аймгийнхаа хөдөлмөрийн зах зээлийн судалгааг өөрсдийн нөөц боломж болон хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй Олон Улсын төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтээр хийж гүйцэтгэж буйг талархан хүлээн авч дутагдаж буй шаардлагатай төсвийг шийдвэрлэх, холбогдох мэдээллийг төрийн байгууллагуудаас гаргуулан авах, сумдад судалгааны мэдээлэл цуглуулах дэд ажлын хэсэг байгуулах зэрэг арга хэмжээг авч дэмжин ажиллаа.

Энэхүү судалгаа нь бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх чухал баримт бичиг болохын зэрэгцээ манай аймаг, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллага, албан хаагчид бие даан гүйцэтгэснээрээ онцлог болж байна. Мөн албан хаагчид судалгааны арга зүйг эзэмших, энэ чиглэлээр чадавхжих, хөрөнгө мөнгө хэмнэх зэрэг олон давуу тал бий болсныг онцлон дурдмаар байна.

Мөн судалгааг санхүүжүүлж, арга зүйгээр ханган ажилласан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг хамт олон, Швейцарийн хөгжлийн агентлагт судалгааг хийж гүйцэтгэсэн нийт төрийн албан хаагчдын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Миний бие судалгааны үр дүн, дүгнэлт, санал зөвлөмжийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагууд, сум орон нутгийн удирдлагууд хамтран ажилладаг Олон Улсын байгууллага болон хувийн хэвшил, иргэд олон нийтийн анхаарлыг энэ салбарт хандуулан хамтын зүтгэлээр амжилт гаргахын төлөө ажиллах болно.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: Ш.ИДЭРБАЯСГАЛАН**



ӨМНӨХ ҮГ

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь байгууллагын хүний нөөцийн дотоод боломж нөөцөөр Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлсэн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл болон аймаг орон нутгийн санхүүгийн дэмжлэгт тулгуурлан аймгийнхаа хөдөлмөрийн зах зээлийн судалгааг анх удаа хийж гүйцэтгэлээ.

Аймаг, орон нутгийн хөгжил дэвшлийг эрчимжүүлэх хүн ардын амьжиргааны түвшинг дээшлүүлэх цаашлаад нийгмийн тулгамдсан асуудал болох ажилгүйдэл, ядуурал болон гэмт хэрэг зэрэг суурь шинжтэй олон асуудлын шийдэл нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал. Үүнийг судлан шинжлэх, орон нутгийн хэмжээнд оношлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж бодлого хөтөлбөр, үйл ажиллагаа төлөвлөх, хэрэгжүүлэхэд юуны өмнө хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Манай байгууллага нь энэхүү судалгааг 2019 оноос хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж сургалт, мэдээлэл, уулзалтын үйл ажиллагааг зохион байгуулсан ч хөрөнгө мөнгөний болон бусад асуудлаас шалтгаалан хойшлогдсоор ирсэн юм.

2021 оны 4-р сард судалгааг хийж гүйцэтгэхээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг томилж, аймгийн Засаг даргаар удирдамж батлуулан 23 сум 1 тосгонд судалгааны мэдээлэл цуглуулах дэд ажлын хэсэг байгуулж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг хамт олонтой хамтран судалгааны арга зүй, аргачлалын талаар удаа дараагийн сургалт зохион байгуулж, судалгааны баг, ажлын хэсгийг чадавхжуулан энэхүү ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны хүрээнд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хөдөлмөрийн салбарын дата мэдээллүүдийг аж ахуй нэгж байгууллагуудаас цуглуулан дүн шинжилгээ хийх, зорилтот 9 сегментээс нийт 8044 иргэнээс санал асуулга авч судалгааг зохион байгуулах, судалгааны чанарын аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулах, ажлын байрны зар мэдээнд дүн шинжилгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн судалгааны тайланг бэлтгэлээ.

Судалгааг зохион байгуулахад санхүүгийн болон арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажилласан Швейцарийн хөгжлийн агентлаг, Т.Энхтуяа захиралтай Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн баг хамт олон, Аймгийн засаг дарга Ш.Идэрбаясгалан болон хамтран ажилласан байгууллагууд, судалгааг зохион байгуулсан ажлын хэсэг, сумдад зохион байгуулагдан ажилласан дэд ажлын хэсгүүдэд талархал илэрхийлж ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА: Б.ЭРДЭНЭХУЯГ**

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Зорилт, арга, судлах зүйл
- Хүснэгт 2. Хамрах хүрээ
- Хүснэгт 3. Хөвсгөл аймгийн харьяат хүн ам
- Хүснэгт 4. Хүн амын тоо
- Хүснэгт 5. Хүн амын тоо сүүлийн 10 жилийн өсөлтийн дундаж хувь
- Хүснэгт 6. Өрхөд тоологдсон хүн ам
- Хүснэгт 7. Өрхийн тоо, түүний хэлбэр
- Хүснэгт 8. 15, түүнээс дээш насны хүн ам
- Хүснэгт 9. Хөдөлмөрийн насны хүн ам сумдаар
- Хүснэгт 10. Ажиллах хүч 2020 оны байдлаар, насны ангиллаар
- Хүснэгт 11. Ажиллах хүч ажил эрхэлдэг хүн ам болон ажил идэвхтэй хайгч насны бүлгээр
- Хүснэгт 12. Ажиллах хүч, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин сумдаар
- Хүснэгт 13. Ажил эрхэлж буй хүн ам сумд, насны бүлгээр
- Хүснэгт 14. 15, түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйс дүнд эзлэх хувиар
- Хүснэгт 15. Ажил эрхэлдэг хүн ам ажил, мэргэжлийн ангилал сумдаар
- Хүснэгт 16. Ажил эрхэлдэг хүн ам эдийн засгийн салбар, хүйс, хот хөдөөгийн ангиллаар
- Хүснэгт 17. Ажил эрхэлж буй хүн ам эдийн засгийн салбар, сумдаар
- Хүснэгт 18. Ажил эрхэлж байгаа хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн статусаар
- Хүснэгт 19. Ажил эрхэлж буй хүн ам боловсрол, насны ангиллаар
- Хүснэгт 20. Ажил эрхэлж буй хүн амыг боловсролын түвшинг сумдаар авч үзэхэд
- Хүснэгт 21. Эдийн засгийн идэвхгүй хүн ам насны бүлгээр
- Хүснэгт 22. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, насны бүлгээр
- Хүснэгт 23. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь сумдаар
- Хүснэгт 24. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын боловсролын түвшин сумдаар
- Хүснэгт 25. 2020-2021 оны хичээлийн жилд суралцсан сурагчид сумдаар
- Хүснэгт 26. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид сүүлийн 6 жилээр
- Хүснэгт 27. Сурагчдын сонгосон мэргэжлийн чиглэл
- Хүснэгт 28. Оюутнууд суралцаж буй курс болон сумдаар
- Хүснэгт 29. Суралцаж буй мэргэжил /курсээр/
- Хүснэгт 30. Суралцаж буй сургууль, курсээр
- Хүснэгт 31. Төгсөөд хаана ажиллаж амьдрах эсэх /Сумдаар/
- Хүснэгт 32. МСҮТ-д суралцагчдын тоо сумдаар
- Хүснэгт 33. 2021-2022 онд МСҮТ-д суралцаж буй суралцагчид мэргэжлийн ангиар
- Хүснэгт 34. 2021-2022 оны хичээлийн жилд МСҮТ-ийн суралцагчид суралцаж буй мэргэжил, сумдаар
- Хүснэгт 35. Төгсөөд хаана ажиллаж амьдрах эсэх сумдаар
- Хүснэгт 36. Сүүлийн 6 жилд МСҮТ-ийг төгсөгчид сумдаар
- Хүснэгт 37. Сүүлийн 6 жилд МСҮТ-ийн төгсөгчид мэргэжлээр
- Хүснэгт 38. Сүүлийн 6 жилд төгссөн МСҮТ-ийн төгсөгчдийг сумдаар харьцуулав
- Хүснэгт 39. Эзэмшсэн мэргэжил, ажиллаж байгаа эсэх
- Хүснэгт 40. Ажил эрхлэхгүй байгаа иргэд боловсролын түвшин, ажиллах сонирхолтой салбараар
- Хүснэгт 41. Ажилд эрхлэхгүй байгаа шалтгаан насны бүлгээр
- Хүснэгт 42. Бүртгэлтэй аж ахуйн нэгж сумдаар
- Хүснэгт 43. Татварын мэдээлэлд буй аж ахуйн нэгж байгууллага сумдаар
- Хүснэгт 44. Төрийн албан хаагчийн тоо сумд, хүйс, албан тушаалын төрлөөр
- Хүснэгт 45. Төрийн албан хаагчид насны ангиллаар
- Хүснэгт 46. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид сумдаар болон нас, хүйсээр
- Хүснэгт 47. Малчин өрхийн тоо сүүлийн 5 жилээр сумдаар
- Хүснэгт 48. Малчдын тоо сүүлийн 5 жилээр сумдаар
- Хүснэгт 49. Малтай өрхийг малын тоогоор
- Хүснэгт 50. Мөрөн сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт
- График 2. 2010, 2020 оны Хөвсгөл аймгийн хүн ам зүйн суварга
- График 3. Хүн амын тоо
- График 4. Хүн амын өсөлтийн хувь
- График 5. Шилжих хөдөлгөөн сүүлийн 10 жилээр
- График 6. Ажиллах хүч, Хөдөлмөр эрхлэлт, Ажилгүйдлийн түвшин 5 жилээр
- График 7. Ажиллах хүч сүүлийн 5 жилээр
- График 8. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо
- График 9. Судалгаанд оролцсон анги бүлэг хувиар
- График 10. Мэргэжлээ сонгосон эсэх, анги бүлгээр
- График 11. Цаашид МСҮТ, Коллеж, Их дээд сургуульд дэвшин суралцах эсэх
- График 12. Сурагчдын Их, дээд сургуульд суралцахгүй шалтгаан
- График 13. Цаашид хаана суралцах эсэх
- График 14. Судалгаанд оролцсон оюутнууд курс, хувиар
- График 15. Төгсөөд хаана ажиллаж амьдрах сонирхолтой вэ?
- График 16. МСҮТ төгсөөд юу хийх төлөвлөгөөтэй байгаа эсэх
- График 17. Төгсөөд хаана ажиллаж амьдрах вэ?
- График 18. Та сургуулиа төгсөөд ямар байгууллагад ажилд орох хүсэлтэй байна вэ?
- График 19. Сүүлийн 6 жилийн Хөвсгөл аймгийн МСҮТ-ийн төгсөлт үзүүлэлт хувиар (2021 оны хаврын төгсөлтийг оруулав)
- График 20. МСҮТ-ийн төгсөгчдийн төлөв
- График 21. Хөдөлмөрийн дутуу ашиглалт
- График 22. Судалгаанд оролцогчид насны бүтцээр
- График 23. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин
- График 24. Ажил эрхлээгүй байсан хугацаа
- График 25. Ажил эрхлэхгүй байгаа шалтгаан
- График 26. Танд хөдөлмөр эрхлэхэд ямар мэдлэг, ур чадвар хандлага дутаж байна?
- График 27. Үйл ажиллагаа явуулсан жил хувиар
- График 28. Шинээр ажилтан авахдаа ямар шаардлага тавьдаг эсэх
- График 29. Ажлаас гарч буй шалтгаан нөлөөлөл
- График 30. Шинээр ажилтан авахдаа ашигладаг мэдээллийн эх үүсвэр
- График 31. Зарлагдсан ажлын байр
- График 32. Зарлагдсан ажлын байранд нарийн мэргэжил шаардлагатай эсэх
- График 33. Зарлагдсан ажлын байрыг салбараар
- График 34. Ажлын зарын төрөл
- График 35. Зарын дагуу ажилтан олж авсан эсэх
- График 36. Зар оруулсан байгууллага өмчлөлийн хэлбэрээр
- График 37. Ажлын байранд ажилтан шинээр авахад анхаарч үздэг шалгуурууд
- График 38. Ажил олгогч ХХҮГ-аар дамжуулан ажлын байрны захиалга өгдөг эсэх
- График 39. Ажиллах хүчний хомсдолын шалтгаан
- График 40. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид үйл ажиллагааны салбараар
- График 41. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал
- График 42. Та өөрийн эрхэлж буй бизнесээ өргөжүүлж аж ахуй нэгж болох сонирхол байгаа юу?
- График 43. Цаашид ямар аж ахуй нэгж байгуулах сонирхолтой вэ?
- График 44. Ажилтан авахад тулгамдаж буй асуудал
- График 45. Туслах малчинтай эсэх
- График 46. Туслах малчинтай эсэх, малын тоо толгойгоор
- График 47. Туслах малчинтай болох бол түүнийгээ ямар шалгуураар сонгож авах вэ?
- График 48. Туслах малчин сонгоход нөлөөлөх хүчин зүйл
- График 49. Малчин өрхөд тулгарч буй хэрэгцээ шаардлага.
- График 50. Танд сургалт, мэдээллийн хэрэгцээ шаардлага байгаа бол ямар чиглэлийн сургалт хэрэгтэй байна?

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны үндэслэл

Хөвсгөл аймгийн хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд засаг захиргааны бүх нэгжийн түвшинд хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой мэдээлэл хэрэгцээтэй болсон өнөө үед Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтийг аймгийн түвшинд тооцож, эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх хэрэгцээ шаардлага өдөр тутамд тулгарч байгаа нь энэхүү судалгааг хийж гүйцэтгэх үндэслэл болж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-р зүйлд:

4.2. Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах бодлогын чиглэлийг баримтална;

4.2.1. Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинг хангах;

4.2.2. Ажиллах хүчний хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;

4.2.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх;

4.2.4. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгааг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар, үр ашгийг дээшлүүлэх; хэмээн заасан.

Хөвсгөл аймгийг 2016-2030 онд хөгжүүлэх “Хөгжсөн Хөвсгөл” хөтөлбөр болон 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд, богино хугацааны бодлого хөтөлбөрүүдэд аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн суурь судалгааг хийж гүйцэтгэх судалгаанаас гарсан үр дүнд тулгуурласан төсөл хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулах талаар зорилго зорилтууд тусгагдсан.

Иймд Хөвсгөл аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж, судалгааны арга зүй боловсруулан боломжит бүх эх үүсвэрээс тоон ба чанарын мэдээллийг цуглуулж, нэгтгэсэн үр дүнг бодлого үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн санг бий болгон судалгааны үр дүнгээс урган гарсан бодит, оновчтой санал зөвлөмжүүдийг боловсруулж, Төрийн болон Аймгийн бодлого тодорхойлох газарт хүргүүлэх үйл ажиллагаанд тусгуулах хэрэгцээ шаардлага үндэслэл урган гарч байна.

Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны гол зорилго нь Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнг нэгдсэн байдлаар судлах, судалгаа шинжилгээ хийн нэгтгэж, дүгнэлт зөвлөмж гарган олон нийтийн хүртээл болгох, түүнчлэн орон нутагт тус судалгааг хийх багийг бүрдүүлэн, чадавхжуулахад чиглэнэ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх болно. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн салбарын 2021 оноос өмнөх таван жилийн статистик тоо баримтыг ашиглан дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийн голлох салбар, мэргэжлээр харьцуулж, дүн шинжилгээ хийх
- Хөвсгөл аймгийн урт болон дунд богино хугацааны бодлого хөтөлбөрүүд дүн шинжилгээ хийх
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тоон судалгааг шинжилгээ хийх
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чанарын судалгаа хийх
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5-р зүйлийн дагуу төрөөс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих талаар жил бүр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар судалгаа хийх
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн суурь судалгааны мэдээллийн сан үүсгэх, тайлан бичих, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах

Судалгааны аргачлал

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнг тодорхойлох суурь судалгааг тоон ба чанарын судалгааны арга зүйг хослуулан явуулна. Үүнд тоон ба чанарын судалгааг явуулахдаа анхдагч ба хоёрдогч мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийнэ.

Хувь хүн, өрх, байгууллагаас мэдээлэл цуглуулахад асуумж, бүлгийн ярилцлагыг үндсэн арга болгохын зэрэгцээ төслийн гол оролцогч талуудаас экспертийн болон ганцаарчилсан сурвалжлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулна. Анкетын аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхдээ “SPSS-26.0” багц программыг ашиглан боловсруулав.

Цуглуулсан мэдээлэлд анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг тооцохын зэрэгцээ, шинээр хувьсагч үүсгэх, логик ангилал гаргах, харьцуулалт болоод статистик шинжилгээ зэрэг мэдээлэл боловсруулалтыг хийж нэгтгэн дүгнэсэн.

Хүснэгт 1. Зорилт, арга, судлах зүйл

	Зорилт	Судалгааны арга	Сонгох баримт, судлах зүйл
1	Холбогдох бодлогын баримт бичиг, мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Баримт бичгийн судалгаа	Олон Улсын болон үндэсний хэмжээнд түгээмэл хэрэглэж буй мэдээлэл цуглуулах арга зүй, аймаг, сумдын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, эрэлт нийлүүлэлтийн чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, материал, бодлогын баримт бичиг, статистик мэдээлэл г.м
2	Нийгмийн бүлгүүдээс асуумжийн аргаар судалгаа авах	Асуумж судалгаа	Судалгааны зорилго, зорилттой уялдуулан нийт ажил олгогч, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид болон ажилгүй иргэд, ажил хөдөлмөр эрхэлж буй залуучууд, их, дээд сургуулийн оюутнууд, төрийн албан хаагчдыг хамруулах стандарт асуумж
3	Нийгмийн бүлгүүдэд тулгамдаж буй хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн онцлог, нөхцөлд байдалд тулгуурлаж, аймгийн төв сумдад бүлгийн ярилцлагад сонгон хамруулах	Ганцаарчилсан ба бүлгийн ярилцлага	Аймаг, сумдын түвшинд хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдээс чанарын мэдээлэл олж авах

• Баримт бичгийн шинжилгээ

Олон Улсын болон үндэсний хэмжээнд түгээмэл хэрэглэж буй мэдээлэл цуглуулах арга зүйгээр аймаг, сумдын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, эрэлт нийлүүлэлтийн чиглэлээр хийгдсэн статистик мэдээлэл, судалгааны тайлан, материал, баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийнэ.

• Анкет-асуумжийн арга

Судалгааны зорилго, зорилттой уялдуулан нийт ажил олгогч, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид болон ажилгүй иргэд, ажил хөдөлмөр эрхэлж буй залуучууд, их, дээд сургуулийн оюутнууд, төрийн албан хаагчдыг хамруулж, стандарт асуумжийн маягт ашиглан мэдээлэл цуглуулна. Түүврийн тоо хэмжээг захиалагчтай дахин тохирч, нарийвчлах шаардлагатай.

• Ганцаарчилсан ба бүлгийн сурвалжилга хийх

Аймаг, сумдын түвшинд хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэдээс нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага

хийнэ. Нийгмийн бүлгүүдэд тулгамдаж буй хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийн онцлог, нөхцөлд байдалд тулгуурлаж, аймгийн төв сумдад бүлгийн ярилцлагад сонгон хамруулах болно.

Судалгааны түүвэр

Түүврийн тоо хэмжээг тоон болон чанарын аргын хувьд харилцан адилгүй тогтооно. Судалгаа хийх талбар болон түүврийн тоо хэмжээг *Зураг 2*-оос үзнэ үү. Түүврийн хэмжээг тогтоохдоо дараах томъёоллоор тооцно. Үүнд:

$$n = \frac{Z^2 * (P_0) * (1 - P_0)}{e^2}$$

- Z^2 = хүсэж буюу ач холбогдлыг тодорхойлсон статистик утга
- P_0 = түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
- e = алдааны хязгаар

Жич: Ач холбогдлын түвшин 95%, алдах магадлалыг 5% байхаар тооцно. Төслийн үр шимийг шууд хүртэх) бүлгийн зэрэгцээ шууд бус байдлаар хүртэх иргэдийн тоо тодорхойгүй байгаа тул $P = 0.05$ гэсэн стандарт утгаар авч тооцсон болно.

Судалгааны мэдээлэл цуглуулах хүрээ

Мэдээллийн түүврийн тооцоолол, тоо хэмжээнд нийцүүлэн дараах оролцогчдоос түүвэрлэлтийг мужилсан хэлбэрээр хийх болно. Судалгаанд баримт бичгийн судалгаа, санал асуулга, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргыг тус тус ашиглана.

Хүснэгт 2. Хамрах хүрээ

№	Судалгааны зорилгод бүлэг	Түүврийн хэмжээ
1	Ажил олгогч	223
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	807
3	Ажилгүй иргэн	1218
4	Оюутан	1041
5	Сурагчид	2147
6	Малчид	1037
7	МСҮТ-д суралцагчид	287
8	МСҮТ төгсөгч	135
9	Ажилтай иргэн	1149
	Нийт	8044

Санал асуулгын аргаар хувийн хэвшлийн ажил олгогчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчид, төрийн байгууллагууд, залуучууд, ажилгүй иргэдээс эрэлтийн мэдээлэл авна. Үүний зэрэгцээ мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлага, иргэдийн дунд бүлгийн ярилцлага, батлагдсан орон тоо, норм норматив болон ажлын зар, статистик мэдээлэлд баримт бичгийн агуулгын шинжилгээг тус тус хийх болно.

Судалгааны зохион байгуулалт.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Швейцарийн хөгжлийн агентлаг, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилтээр Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж гүйцэтгэхээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/12 тоот тушаалаар судалгааг хийж гүйцэтгэх ажлын хэсэг байгуулагдсан.

Аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгаланд судалгааны ажлын хэсэг судалгааны төлөвлөгөө, шаардлагатай төсөв, анхдагч мэдээлэл цуглуулах арга аргачлалын талаар танилцуулж, төрийн байгууллага, агентлаг, хэлтсүүдээс судалгаанд шаардлагатай мэдээллийг гарган авах мөн сумдад анхдагч мэдээлэл цуглуулах дэд ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Энэ

хүрээнд сумын Засаг даргын захирамжаар сум бүрд судалгааны мэдээлэл цуглуулах дэд ажлын хэсгүүд байгуулагдан мэдээлэл цуглуулж ажилласан.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны талаарх арга зүйн сургалтыг “Zoom” цахим платформ ашиглан дэд ажлын хэсгийн гишүүдийг оролцуулан дөрвөн удаа зохион байгуулсан. Энэхүү сургалтад Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн зөвлөх Д.Хадхүү, сургагч багш Н.Нарангэрэл, Д.Бүжинлхам нар оролцож сургалт мэдээлэл хийсэн.

2021 оны 05 сарын 17-ны өдрөөс 06 сарын 11-ний өдрүүдэд аймгийн засаг даргын баталсан удирдамжаар сумдад байгуулагдсан ажлын хэсгүүдийг удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажиллаж нийт 100 ажил олгогч, 2115 сурагч, 1049 оюутан, 140 МСҮТөвд суралцагч, төгсөгч, 1451 ажилгүй иргэн, 1451 ажилтай иргэн, 1023 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1124 малчнаас судалгааны мэдээллийг цуглууллаа.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад ажлын хэсгийн гишүүд 22 суманд 6 багт хуваагдан ажиллаж судалгааны анхдагч мэдээллийг цуглуулах дэд ажлын хэсэгт сургалт мэдээлэл хийж, судалгааны явцад хяналт тавьж, бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж ажилласан.

НЭГ: ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

1.1 Хүн амын ерөнхий мэдээлэл

2020 онд хийгдсэн Хүн ам, орон сууцны ээлжит тооллогоор Хөвсгөл аймгийн харьяат хүн ам 135095. Үүнээс гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа иргэн 933. Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол Улсын харьяат иргэн 134.162 байна.

Энэхүү хүн амын тооллогын хугацаанд Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт 134.318 хүн оршин сууж байгаа бөгөөд 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат 155 иргэн байна.

Хүснэгт 3. Хөвсгөл аймгийн харьяат хүн ам




Хөвсгөл аймгийн хүн амыг байршлаар нь ангилж үзэхэд 32.9 хувь нь хотод, 67.1 хувь нь хөдөө орон нутагт оршин сууж байгааг 2010 оны тооллоготой харьцуулахад хотынх 23.4 хувиар, хөдөөд 14.8 хувиар нэмэгдсэн нь хотжилт сүүлийн 10 жилд идэвхтэй явагдаж байгааг харуулж байна. Үүнээс 30.3 хувь нь Мөрөн суманд оршин сууж байгаа юм.

Хүснэгт 4. Хүн амын тоо

Сум	Хүний тоо (2020)	Эзлэх хувь(2020) %
Бүгд	134 318	100.0
Хот	44 188	32.9
Хөдөө	90 130	67.1


Хөвсгөл аймгийн хүн амын өсөлтийг авч үзэхэд 2020 онд өмнөх оноос төрөлт болон цэвэр өсөлт буурсан хандлагатай байгаа бол нас баралтын тоо хэмжээ тогтмол үзүүлэлттэй. Сүүлийн 6 жилээр авч үзэхэд хүн амын ердийн цэвэр өсөлт дунджаар 17.2 хувь байна. Нас баралтын эзлэх хувь тогтвортой боловч шинэ төрөлтийн эзлэх хувиас шалтгаалан хүн амын цэвэр өсөлт 1 орчим хувиар хэлбэлзэж байна.

График 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хөвсгөл аймгийн хүн амыг 10 жилийн өмнөхтэй харьцуулан нас, хүйсийн суваргаар авч үзэхэд 5-9 нас болон 25-34 насны эзлэх хувь өссөн үзүүлэлтэй байна.

График 2. 2010, 2020 оны Хөвсгөл аймгийн хүн ам зүйн суварга




Сүүлийн 10 жилийн хугацаанд хүн амын өсөлтийг авч үзэхэд 2014 онд Хөвсгөл аймгийн хүн амын тоо 117645-аас 126043 болж 6.2 хувь буюу хамгийн өндөр хувиар өсжээ. 2014 онд төв суурин газрын хүн ам өмнөх оноос буурсан үзүүлэлттэй бол хөдөө орон нутагт энэхүү тоо хэмжээ хамгийн өндөр хувиар өссөн байна.

График 3. Хүн амын тоо




График 4. Хүн амын өсөлтийн хувь



Хүн амын шилжих хөдөлгөөнөөс үзэхэд 2014 онд шилжин явсан иргэд сүүлийн 10 жил хамгийн их буюу 2358 байна. Мөн энэ онд Хөвсгөл аймгийн хүн амын өсөлт хамгийн их буюу 6.2 хувьтай байжээ. Энэхүү хүн амын өсөлтөд төрөлт, болон төрийн үйл ажил ажиллагаанд нэвтэрсэн бүртгэлийн системүүд түүн дээр ажиллагсдын нөлөөлөл орсон байх магадлалтай. Шилжих хөдөлгөөний зөрүү сүүлийн 4 жилийн хугацаанд харьцангуй тогтворжиж байгаа бөгөөд 2017, 2018 онуудад шилжсэн ирсэн иргэд нь явсан иргэдээсээ олон байсан байна.

График 5. Шилжих хөдөлгөөн сүүлийн 10 жилээр



Хөвсгөл аймгийн хүн амын тоог 2000, 2010 онтой харьцуулан үзэхэд Рашаант, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Ханх, Мөрөн, Цагааннуур гэсэн 6 сум өсөлттэй бусад сумдын хүн амын тоо буурч байжээ.

2010 оныг 2020 онтой харьцуулахад Хөвсгөл аймгийн бүх сумд хүн ам өсөлттэй гэсэн дүн гарчээ. Үүн дотроос Алаг-Эрдэнэ, Цагааннуур, Түнэл, Бүрэнтогтох зэрэг сумд хамгийн өндөр өсөлттэй байна.

Хүснэгт 5. Хүн амын тоо сүүлийн 10 жилийн өсөлтийн дундаж хувь

Сумд	Хүн амын тоо	Дүнд эзлэх хувь	1 км ² -т ногдох хүн ам	2010-2020 он жилийн дундаж өсөлт
БҮГД	134318	100	1.3	1.9
Алаг-Эрдэнэ	6 743	5.0	1.2	3.9
Арбулаг	4 032	3.0	1.1	2.8
Баянзүрх	3 983	3.0	0.9	2.1
Бүрэнтогтох	4 405	3.3	1.2	2.9
Галт	5 430	4.0	1.5	2.2
Жаргалант	5 548	4.1	2.2	2.7
Их-Уул	4 110	3.1	2.0	1.1
Рашаант	3 794	2.8	1.9	1.4
Рэнчинлхүмбэ	4 863	3.6	0.6	0.8
Тариалан	6 209	4.6	1.8	2.3
Тосонцэнгэл	4 451	3.3	2.2	2.5
Төмөрбулаг	4 315	3.2	1.7	1.9
Түнэл	4 323	3.2	1.2	2.9
Улаан-Уул	4 242	3.2	0.4	0.7
Ханх	2 818	2.1	0.5	1.9
Цагааннуур	1 979	1.5	0.4	3.4

Цагаан-Уул	5 699	4.2	0.9	2.3
Цагаан-Үүр	2 671	2.0	0.3	1.8
Цэцэрлэг	4 658	3.5	0.6	1.7
Чандмань-Өндөр	3 073	2.3	0.7	1.0
Шинэ-Идэр	3 185	2.4	1.6	2.5
Мөрөн	40 770	30.4	396.2	1.5
Эрдэнэбулган	3 017	2.2	0.6	2.8

1.1 Өрхийн ерөнхий мэдээлэл


2020 онд хийгдсэн хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс үзэхэд 37 914 өрхөд суурин хүн амын 98.3 хувь нь буюу 132 137 хүн өрхийн гишүүнээр үлдсэн 1.7 хувь нь өрх үүсгээгүй нэгжид тоологджээ.

Хүснэгт 6. Өрхөд тоологдсон хүн ам



Өрхийн тоог хэлбэрээр нь авч үзэхэд нийт өрхийн 68.7 хувь нь ам бүлээрээ, 15.5 хувь нь ганц бие, 15.2 хувь нь нийлмэл, 0.6 хувь нь холимог өрх байна.

Хүснэгт 7. Өрхийн тоо, түүний хэлбэр



1.3 Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийн өнөөгийн байдал

Хөвсгөл аймаг 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны нийт 91813 хүн амтай. Үүний 55096 хүн нь ажиллах хүч бол ажил идэвхтэй хайгчаар бүртгүүлсэн 2884, ажил эрхэлдэг 52212 хүн байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 36717 байгаа бол үүний 40 орчим хувь нь буюу 14496 хүн шат шатны сургуульд боловсрол эзэмшиж байгаа юм. Тохирох ажил олдохгүй гэсэн шалтгаанаар 5497 хүн ажил эрхлээгүй байгаа гэж тоологджээ.

Хүснэгт 8. 15, түүнээс дээш насны хүн ам



Хөдөлмөрийн насны хүн амыг сумдаар авч үзэхэд ажиллах хүчний 27.7 хувь, ажиллах хүчнээс гадуурх хүн амын 34.4 хувь нь Мөрөн суманд оршин сууж байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амд багтаж байгаа тохирох ажил олдохгүй гэсэн ангилалд байгаа 5497 хүний 39.3 хувь нь мөн Мөрөн суманд байна.


Хүснэгт 9. Хөдөлмөрийн насны хүн ам сумдаар

СУМД	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Мөрөн	15245	13658	1587	12618	4549	3218	774	1247	2160	60	610
Алаг-Эрдэнэ	2795	2674	121	1826	673	458	103	88	395	2	107
Арбулаг	1850	1814	36	835	405	175	31	38	73	1	112
Баянзүрх	1899	1873	26	747	355	175	58	65	69	6	19
Бүрэнтогтох	1952	1920	32	1015	405	338	59	31	159	4	19
Галт сум	2400	2385	15	1303	709	281	50	71	159	2	31
Жаргалант	2195	2178	17	1591	707	296	71	228	252	7	30
Их-Уул	1856	1830	26	1001	440	312	64	29	98	0	58
Рашаант	1618	1572	46	994	447	235	46	99	135	1	31
Рэнчинлхүмбэ	2198	2179	19	1169	440	357	83	88	152	4	45
Тариалан	2565	2414	151	1717	649	511	104	158	154	5	136
Тосонцэнгэл	1926	1828	98	1041	488	284	74	69	98	9	19
Төмөрбулаг	1927	1838	89	1031	506	194	82	45	179	1	24
Түнэл	1770	1587	183	1159	471	264	54	30	208	3	129
Улаан-Уул	1533	1471	62	1397	466	319	37	263	136	18	158
Ханх	975	940	35	967	271	176	38	81	174	1	226
Цагааннуур	715	678	37	573	187	101	38	47	159	1	40
Цагаан-Уул	2640	2609	31	1163	614	312	70	46	52	1	68
Цагаан-Үүр	996	982	14	892	302	206	60	158	149	5	12
Цэцэрлэг	2140	2061	79	1099	463	296	70	126	110	4	30
Чандмань-Өндөр	1357	1285	72	793	281	191	58	41	171	21	30
Шинэ-Идэр	1240	1222	18	999	338	248	51	67	174	4	117
Эрдэнэбулган	1304	1214	90	787	330	216	37	67	81	11	45
НИЙТ	55096	52212	2884	36717	14496	9163	2112	3182	5497	171	2096

1.4 Ажиллах хүчний төлөв байдал


Хөвсгөл аймгийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн түвшинг¹ сүүлийн таван жилээр авч үзэхэд 61.5 хувийн дундажтай байгаа ажиллах хүчний оролцооны түвшин² 67.5 хувийн дундажтай ажилгүйдлийн түвшин³ 8.9 хувийн дундажтай байгаа нь харьцангуй тогтмол үзүүлэлт болж байна.

График 6. Ажиллах хүч, Хөдөлмөр эрхлэлт, Ажилгүйдлийн түвшин 5 жилээр



Ажиллах хүчний⁴ тоог авч үзэхэд 2014 оноос тасралтгүй өсөж 2017 онд 61.6 мянга болсон бол 2017 оноос хойш буурсаар 2020 оны байдлаар 55.4 мянган хүн болжээ. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 55 096 хүн байгаагаас Хөвсгөл аймагт бодит ажиллах хүч 55 мянга гаруй байна хэмээн дүгнэж болохоор байна.

График 7. Ажиллах хүч сүүлийн 5 жилээр



1 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм.

2 Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

3 Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно

4 Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэгдэлд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

Ажиллах хүчийг 2020 оны байдлаар насны ангиллаар авч үзэхэд 15-19 насны 8.6 хувь буюу 886 хүн, 20-24 насны 43.5 хувь буюу 4611 хүн, 60-аас дээш насны 21.6 хувь буюу 2034 хүн ажиллах хүчинд хамаарч байна.

35-44 насны хүн ам хамгийн өндөр буюу 82.7 хувь нь 14964 хүн ажиллах хүчинд хамаарч байна. Ажиллах хүчний насны ангиллын хувьд хамгийн олон хүн буюу 16714 хүн нь 25-34 насны бүлэг байгаа бөгөөд нь энэ нь тухайн насныхаа хүн амын 77.2 хувийг эзэлж байгаа юм. Ажиллах хүчийг насны бүлгээр авч үзэхэд 15-24 насны иргэдийн 25 хувь нь буюу 4 хүн тутмын 1 нь л ажиллах хүчинд хамаарч байна.

Хүснэгт 10. Ажиллах хүч 2020 оны байдлаар, насны ангиллаар

Насны бүлэг	Ажиллах хүч	
	Бүгд	
	Хүний тоо	Ажиллах хүчний оролцооны түвшин
БҮГД	55096	60
15-19	886	8.6
20-24	4611	43.5
25-34	16714	77.2
35-44	14964	82.7
45-54	12414	79.5
55-59	3473	56.0
60+	2034	21.6

Ажиллах хүчийг насны бүлгүүдээр, ажил эрхэлж байгаа болон ажил идэвхтэй хайж байгаа иргэдээр ангилж, дүн шинжилгээ хийв. Ажил идэвхтэй хайж байгаа иргэд нь ажиллах хүчний 5 хувийг эзэлж байгаа бөгөөд 25-34 насны иргэд бусад насны бүлгээс илүү ажил идэвхтэй хайгчаар бүртгүүлэх хандлагатай байна.

Хүснэгт 11. Ажиллах хүч ажил эрхэлдэг хүн ам болон ажил идэвхтэй хайгч насны бүлгээр

		Ажиллах хүч		
		Ажил эрхэлдэг хүн ам	Ажил идэвхтэй хайж байгаа	Ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн эзлэх хувь
Насны бүлэг	Бүгд	52212	2884	5
	15-19	859	27	3
	20-24	4402	209	5
	25-29	7366	508	6
	30-34	8288	552	6
	35-39	7036	399	5
	40-44	7163	366	5
	45-49	6577	350	5
	50-54	5228	259	5
	55-59	3305	168	5
	60-64	1216	35	3
	65-69	443	7	2
	70+	329	4	1

Хөвсгөл аймгийн ажиллах хүчний тоог сумдаар авч үзэн ажиллах хүчний оролцооны түвшинг тооцоход Баянзүрх, Арбулаг, Цагаан-Уул сумд аймгийн дунджаас 8-11 хувиар өндөр байгаа бол Ханх, Улаан-Уул, Цагаан-Үүр сумд аймгийн дундаж түвшнөөс 7-10 хувиар бага байна.

Хүснэгт 12. Ажиллах хүч, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин сумдаар

№		Ажиллах хүч			15, түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүчний оролцооны түвшин	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
		Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа			
	Бүгд	55096	52212	2884	91813	60	57
1	Мөрөн	15245	13658	1587	27863	55	49
2	Алаг-Эрдэнэ	2795	2674	121	4621	60	58
3	Арбулаг	1850	1814	36	2685	69	68
4	Баянзүрх	1899	1873	26	2646	72	71
5	Бүрэнтогтох	1952	1920	32	2967	66	65
6	Галт	2400	2385	15	3703	65	64
7	Жаргалант	2195	2178	17	3786	58	58
8	Их-Уул	1856	1830	26	2857	65	64
9	Рашаант	1618	1572	46	2612	62	60
10	Рэнчинлхүмбэ	2198	2179	19	3367	65	65
11	Тариалан	2565	2414	151	4282	60	56
12	Тосонцэнгэл	1926	1828	98	2967	65	62
13	Төмөрбулаг	1927	1838	89	2958	65	62
14	Түнэл	1770	1587	183	2929	60	54
15	Улаан-Уул	1533	1471	62	2930	52	50
16	Ханх	975	940	35	1942	50	48
17	Цагааннуур	715	678	37	1288	56	53
18	Цагаан-Уул	2640	2609	31	3803	69	69
19	Цагаан-Үүр	996	982	14	1888	53	52
20	Цэцэрлэг	2140	2061	79	3239	66	64
21	Чандмань-Өндөр	1357	1285	72	2150	63	60
22	Шинэ-Идэр	1240	1222	18	2239	55	55
23	Эрдэнэбулган	1304	1214	90	2091	62	58

Ажил эрхэлж буй хүн амыг сум, насны бүлгээр ангилан үзэхэд 15-24 насны бүлэгт Баянзүрх сум аймгийн дунджаас 6 хувиар илүү ажил эрхлэлттэй байгаа бол Арбулаг, Рэнчинлүмбэ, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумын хүн ам дунджаас 3 хувиар илүү ажил эрхэлж байна. Харин энэ насны бүлэгт Цагаан-Үүр сум аймгийн дунджаас 4 хувь доогуур, Түнэл, Галт сумд 2 хувиар доогуур үзүүлэлттэй ажил эрхэлж байгааг харж болохоор байна.

25-34 насны бүлэгт Цагааннуур сум дунджаас 5 хувиар илүү, Шинэ-Идэр, Рашаант сумд 4 хувиар доогуур байна. 35-44 насны бүлэгт Их-Уул, Рашаант, Төмөрбулаг сумд аймгийн дунджаас 3 хувиар илүү байгаа бол Улаан-Уул, Цагааннуур, Цагаан-Үүр сумд аймгийн дунджаас 3 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13. Ажил эрхэлж буй хүн ам сумд, насны бүлгээр

№	Сумдаар	Насны бүлэг										
		Бүгд	15-24	Хувь	25-34	Хувь	35-44	Хувь	45-54	Хувь	55+	Хувь
	Бүгд	52212	5261	10	15654	30	14199	27	11805	23	5293	10
1	Мөрөн	13658	1067	8	4341	32	3692	27	3319	24	1239	9
2	Алаг-Эрдэнэ	2674	283	11	826	31	672	25	577	22	316	12
3	Арбулаг	1814	228	13	572	32	453	25	353	19	208	11
4	Баянзүрх	1873	294	16	536	29	475	25	361	19	207	11
5	Бүрэнтогтох	1920	177	9	599	31	522	27	411	21	211	11
6	Галт	2385	202	8	743	31	694	29	498	21	248	10
7	Жаргалант	2178	232	11	655	30	595	27	485	22	211	10
8	Их-Уул	1830	189	10	459	25	545	30	425	23	212	12
9	Рашаант	1572	188	12	414	26	476	30	342	22	152	10
10	Рэнчинлхүмбэ	2179	284	13	673	31	578	27	453	21	191	9
11	Тариалан	2414	219	9	711	29	638	26	579	24	267	11
12	Тосонцэнгэл	1828	220	12	519	28	533	29	408	22	148	8
13	Төмөрбулаг	1838	210	11	478	26	552	30	411	22	187	10
14	Түнэл	1587	134	8	528	33	432	27	353	22	140	9
15	Улаан-Уул	1471	195	13	453	31	353	24	333	23	137	9
16	Ханх	940	103	11	265	28	273	29	204	22	95	10
17	Цагааннуур	678	74	11	239	35	164	24	133	20	68	10
18	Цагаан-Уул	2609	286	11	738	28	741	28	596	23	248	10
19	Цагаан-Үүр	982	62	6	310	32	236	24	233	24	141	14
20	Цэцэрлэг	2061	227	11	560	27	592	29	454	22	228	11
21	Чандмань-Өндөр	1285	162	13	343	27	316	25	314	24	150	12
22	Шинэ-Идэр	1222	105	9	322	26	350	29	312	26	133	11
23	Эрдэнэбулган	1214	120	10	370	30	317	26	251	21	156	13

Ажил хөдөлмөр эрхэлдэг хүн амыг ажил мэргэжлийн ангилал, насны бүлгээр авч үзэхэд 52212 хүний 52.9 хувь буюу 27604 иргэн хөдөө аж ахуйн салбарт, 6269 иргэн буюу 12 хувь нь мэргэжилтний ангилалд, 5355 хүн буюу 10.3 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт ажиллаж байна. Харин 1262 хүн буюу 24 хувь нь техникч болон туслах ангилалд, 2405 хүн буюу нийт ажиллагсдын 4.6 хувь нь үйлдвэрлэл барилга, гар урлалд холбогдох ажил, үйлчилгээний ангилалд багтахар байгаа юм.

Хүн амын эрхэлдэг ажил мэргэжлийн онцлогоос хамаарч ажил эрхэлдэг хүмүүсийн хүйсийн ялгаа тус бүрд өөр өөр байна. Эрхэлдэг ажил мэргэжил хүйсийн хувьд хамгийн бага зөрүүтэй байгаа нь менежер, техникч болон туслах (дэд мэргэжилтэн) энгийн ажил мэргэжлүүд байгаа юм. Эрэгтэйчүүдийн хувьд 67.1 хувь нь мэргэжлийн буюу зонхилох мэргэжил нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, үйлчилгээний ажилтан, машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, зэвсэгт хүчний ажил, мэргэжлийн ажлуудыг хийж байгаа бол эмэгтэйчүүд мэргэжилтэн болон худалдаа үйлчилгээний ажилтны ангилалд илүүтэй ажиллаж байна.

Хүснэгт 14. 15 түүнээс дээш насны ажил эрхэлдэг хүн амын тоо, ажил мэргэжлийн ангилал, хүйс дүнд эзлэх хувиар

Ажил мэргэжил	Ажил эрхлэгчдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	52212	27923	24289	100.0	100.0	100.0
Менежер	2244	1194	1050	4.3	4.3	4.3
Мэргэжилтэн	6269	1912	4357	12.0	6.8	17.9
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	1262	597	665	2.4	2.1	2.7
Контор, үйлчилгээний ажилтан	1055	371	684	2.0	1.3	2.8
Худалдаа үйлчилгээний ажилтан	5355	2024	3331	10.3	7.2	13.7
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	27604	15730	11874	52.9	56.3	48.9
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	2407	1614	793	4.6	5.8	3.3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	2240	2141	99	4.3	7.7	0.4
Энгийн ажил мэргэжил	2886	1528	1358	5.5	5.5	5.6
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	890	812	78	1.7	2.9	0.3

Ажил хөдөлмөр эрхэлдэг хүн амын тоог ажил мэргэжлийн ангиллаар сумдаар авч үзэхэд хөдөлмөрийн зах зээл илүү эрэлттэй байгаа техникч болон туслах ангилалд Мөрөн суманд 624 байгаа бол Цагааннуур, Ханх, Түнэл, Шинэ-Идэр сумдад хамгийн бага байна.

Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Галт, Арбулаг сумдын ажиллах хүчний 77-79 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас, агнуурын ангилалд ажиллаж байна.

Хүснэгт 15. Ажил эрхэлдэг хүн ам ажил, мэргэжлийн ангилал сумдаар

	Бүгд	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	Контор, үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	Энгийн ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил
Бүгд	52212	2244	6269	1262	1055	5355	27604	2407	2240	2886	890
Мөрөн	13658	1140	2752	624	462	3347	1242	1339	1315	1157	280
Алаг-Эрдэнэ	2674	113	280	51	55	224	1525	126	83	198	19
Арбулаг	1814	43	121	28	25	63	1393	39	32	53	17

Баянзүрх	1873	47	145	20	24	57	1365	74	34	50	57
Бүрэнтогтох	1920	49	136	33	29	77	1425	47	29	80	15
Галт	2385	49	184	26	36	85	1848	20	39	83	15
Жаргалант	2178	56	282	37	27	113	1415	99	50	64	35
Их-Уул	1830	51	170	33	28	91	1194	88	86	72	17
Рашаант	1572	42	139	20	21	82	1099	61	44	54	10
Рэнчинлхүмбэ	2179	42	175	24	31	61	1716	22	31	50	27
Тариалан	2414	85	217	59	46	245	1357	99	102	187	17
Тосонцэнгэл	1828	54	169	29	24	66	1338	38	27	57	26
Төмөрбулаг	1838	47	119	27	23	90	1368	55	30	45	34
Түнэл	1587	37	118	18	20	60	1167	28	57	70	12
Улаан-Уул	1471	47	175	30	19	60	953	24	20	86	57
Ханх	940	33	127	12	19	47	557	9	22	70	44
Цагааннуур	678	43	90	13	18	134	270	14	11	48	37
Цагаан-Уул	2609	46	170	45	25	100	2025	41	45	88	24
Цагаан-Үүр	982	44	118	32	20	82	551	32	22	48	33
Цэцэрлэг	2061	63	210	33	32	70	1352	62	80	99	60
Чандмань- Өндөр	1285	33	116	20	23	87	856	45	25	71	9
Шинэ-Идэр	1222	40	143	18	21	47	851	14	19	59	10
Эрдэнэбулган	1214	40	113	30	27	67	737	31	37	97	35

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн амыг эдийн засгийн салбараар хот хөдөө болон хүйсээр авч үзэхэд нийт ажиллагсдын 70 хувь нь хөдөө орон нутагт, 30 орчим хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байна. Ажиллах хүчний гол нөөцийг бүрдүүлж буй хөдөө аж ахуйн салбарын 7 хувь нь хотод 93 хувь нь хөдөөд байна.

Хүснэгт 16. Ажил эрхэлдэг хүн ам эдийн засгийн салбар, хүйс, хот хөдөөгийн ангиллаар

Ажиллах хүч эдийн засгийн салбараар	Хот, Хөдөө								
	Бүгд			Хот			Хөдөө		
	ХҮЙС			ХҮЙС			ХҮЙС		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	52212	27923	24289	14950	7659	7291	37262	20264	16998
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	27698	15785	11913	1907	1133	774	25791	14652	11139
Уул уурхай, олборлолт	727	661	66	356	325	31	371	336	35
Боловсруулах үйлдвэрлэл	2365	1109	1256	1279	607	672	1086	502	584
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	446	354	92	169	124	45	277	230	47
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	297	163	134	260	134	126	37	29	8

Барилга	1511	1240	271	1015	799	216	496	441	55
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээ	3240	1385	1855	2023	815	1208	1217	570	647
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	1390	1255	135	903	813	90	487	442	45
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	582	150	432	378	98	280	204	52	152
Мэдээлэл холбоо	325	171	154	213	108	105	112	63	49
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	732	230	502	387	139	248	345	91	254
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	36	19	17	23	11	12	13	8	5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	549	283	266	305	165	140	244	118	126
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	475	325	150	261	178	83	214	147	67
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	3135	2083	1052	1355	820	535	1780	1263	517
Боловсрол	4810	1216	3594	1793	465	1328	3017	751	2266
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1683	334	1349	770	138	632	913	196	717
Урлаг, үзвэр, тоглоом наадам	361	190	171	140	63	77	221	127	94
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1753	922	831	1353	692	661	400	230	170
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд	73	36	37	44	25	19	29	11	18
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	24	12	12	16	7	9	8	5	3

Ажил хөдөлмөр эрхэлж буй хүн амыг эдийн засгийн салбараар нь сумын түвшинд авч үзэхэд эдийн засгийн зонхилох салбаруудаас бусад гэсэн ангилалд 1753 иргэн байгаагийн 1330 нь буюу 75.9 нь Мөрөнд суманд байна. Энэ нь цаашид Мөрөн суманд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн судалгааг дэлгэрэнгүй гаргах хэрэгцээ шаардлага тулгарч байгааг харуулж байна.

Хүснэгт 17. Ажил эрхэлж буй хүн ам эдийн засгийн салбар, сумдаар

№	Сум	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан дулааны үйлдвэрлэл, усан хангамж	Барилга	Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	Санхүү, зээлийн байгууллага	Үл хөдлөх хөрөнгө, бизнес үйл ажиллагаа	Төрийн байгууллагын үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	Бусад	Нийт
1	Алаг-Эрдэнэ	1571	29	67	10	52	158	32	48	33	1	164	261	74	29	2674
2	Арбулаг	1394	9	17	4	16	42	4	17	16	1	58	134	43	18	1814
3	Баянзүрх	1381	16	43	3	13	51	5	18	18	0	111	133	37	7	1873
4	Бүрэнтогтох	1405	10	44	6	56	68	6	24	14	0	66	135	33	21	1920
5	Галт	1844	11	29	11	8	67	6	24	25	3	79	170	57	14	2385
6	Жаргалант	1424	5	98	11	22	90	18	34	19	0	84	207	44	73	2178
7	Их-Уул	1202	10	53	27	48	82	17	70	14	1	58	126	61	23	1830
8	Рашаант	1117	12	47	8	24	56	8	21	13	1	42	121	42	17	1572
9	Рэнчинлхүмбэ	1709	12	24	3	18	63	14	15	17	0	73	137	46	14	2179
10	Тариалан	1444	25	136	32	71	137	34	49	26	1	85	194	58	33	2414
11	Тосонцэнгэл	1322	14	33	26	16	55	18	21	9	0	63	159	44	15	1828
12	Төмөрбулаг	1269	5	137	15	27	58	4	22	18	0	85	109	34	19	1838
13	Түнэл	1151	20	38	17	25	39	9	35	12	0	57	114	33	11	1587
14	Улаан-Уул	957	11	26	6	11	43	4	14	11	1	129	142	50	13	1471
15	Ханх	553	5	16	3	11	28	4	8	12	0	117	117	26	12	940
16	Цагаан-Уул	2004	14	35	38	19	60	13	25	14	1	89	181	53	21	2609
17	Цагаан-Үүр	560	9	37	8	8	32	6	13	11	1	98	106	34	17	982
18	Цэцэрлэг	1260	126	121	30	19	51	6	21	20	1	135	158	49	15	2061
19	Чандмань-Өндөр	843	16	48	4	19	55	10	14	16	0	64	109	38	14	1285
20	Шинэ-Идэр	843	4	30	15	17	30	1	12	12	1	55	119	43	13	1222
21	Мөрөн	1339	339	1230	163	991	1903	354	863	369	22	1246	1651	730	1330	13658
22	Эрдэнэбулган	746	21	45	5	14	46	6	15	18	1	91	124	31	15	1214
23	Цагааннуур	360	4	11	1	6	26	3	7	15	0	86	103	23	9	678
24	Нийт	27698	727	2365	446	1511	3240	582	1390	732	36	3135	4810	1683	1753	52212

Ажил эрхэлж буй хүн амыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар⁵ авч үзэхэд 18049 хүн байнгын ажиллагч, 23372 хүн өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхлэгч, 8483 хүн өрхийн аж ахуйд хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн, 1611 хүн түр ажиллагч байна.

Ажил эрхэлж байгаа хүн амыг эдийн засгийн салбараар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарт 27698 хүн байгаа бөгөөд үүнд мал аж ахуйн салбарын ажилтнууд хамгийн өндөр хувь жинг эзэлж байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн статусаар 23372 хүн өрхийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа

⁵ Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

эрхэлж байгаа, 8483 хүн тэрхүү аж ахуйд хувь нэмрээ оруулсан гэж үзвэл 31855 хүн болж байна. Үүний 87 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад байна хэмээн дүгнэж болохоор байна.

2021 оны байдлаар тоологдсон байнгын ажиллагч 18049 хүний 7171 хүн буюу 40 хувь нь төрийн албанд ажиллаж байгаа бол үлдсэн 60 хувь нь хувийн хэвшилд ажиллаж байна.

Хүснэгт 18. Ажил эрхэлж байгаа хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн статусаар

№	Сумд	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ										
		Бүгд	Байнгын ажиллагч	Түр ажиллагч	Тохиолдлын ажиллагч	Дагалдан, мэргэшиж буй дадлагажигч	Гүйцэтгэх гэрээлэгч	ААНБ-ын ажил олгогч	Зах зээлд чиглэсэн өрхийн ААН-ийн ажил олгогч	ААНБ-ын үйл ажиллагаа эрхлэгч	Өрхийн ААН-ийн үйл ажиллагаа эрхлэгч	Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн
	Бүгд	52212	18049	1611	234	9	167	114	45	128	23372	8483
1	Мөрөн сум	13658	8113	815	64	3	101	76	28	27	4189	242
2	Алаг-Эрдэнэ сум	2674	858	75	33	2	3	8	5	2	1119	569
3	Арбулаг сум	1814	379	17	2	2	2	2	1	1	1000	408
4	Баянзүрх сум	1873	392	19	3	0	2	1	2	3	825	626
5	Бүрэнтогтох сум	1920	400	30	15	1	4	4	1	3	1179	283
6	Галт сум	2385	489	24	3	0	0	0	1	4	1322	542
7	Жаргалант сум	2178	536	99	5	0	1	5	0	7	1225	300
8	Их-Уул сум	1830	446	49	31	0	6	1	0	5	909	383
9	Рашаант сум	1572	391	39	2	0	6	0	0	2	825	307
10	Рэнчинлхүмбэ сум	2179	405	30	1	0	2	1	0	1	1040	699
11	Тариалан сум	2414	847	77	4	0	16	9	1	4	1341	115
12	Тосонцэнгэл сум	1828	419	32	1	0	0	0	0	1	883	492
13	Төмөрбулаг сум	1838	369	27	22	0	2	0	0	57	943	418
14	Түнэл сум	1587	380	30	0	0	1	1	0	2	791	382
15	Улаан-Уул сум	1471	437	47	5	1	1	0	1	1	648	330
16	Ханх сум	940	344	21	3	0	1	1	0	1	327	242

17	Цагааннуур сум	678	266	23	10	0	4	0	0	0	271	104
18	Цагаан-Уул сум	2609	505	28	7	0	1	1	0	3	1247	817
19	Цагаан-Үүр сум	982	365	21	3	0	5	0	0	0	438	150
20	Цэцэрлэг сум	2061	626	50	5	0	2	2	1	2	825	548
21	Чандмань-Өндөр сум	1285	343	26	4	0	2	0	1	0	742	167
22	Шинэ-Идэр сум	1222	336	13	3	0	0	0	0	0	700	170
23	Эрдэнэбулган сум	1214	403	19	8	0	5	2	3	2	583	189

Ажил эрхэлж буй хүн амыг боловсролын түвшин, насны ангиллаар нь авч үзэхэд бүрэн дунд боловсролтой 14978 буюу 28.7 хувь, бакалаврын дээд боловсролтой 10328 буюу 19.8 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 163, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 1872 хүн байна.

Хүснэгт 19. Ажил эрхэлж буй хүн ам боловсрол, насны ангиллаар

	Боловсролын түвшин										
	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистр	Доктор
Бүгд	52114	1748	8481	11936	14978	1638	1872	275	10328	850	8
15-19	859	36	118	261	376	39	25	1	3	0	0
20-24	4390	126	381	629	1623	174	131	23	1272	31	0
25-29	7356	233	869	860	1976	257	149	27	2847	137	1
30-34	8285	348	1613	1263	2052	180	134	23	2478	193	1
35-39	7029	392	1803	1667	1531	88	115	20	1242	169	2
40-44	7151	180	1260	2429	2120	111	156	20	733	141	1
45-49	6565	91	565	1998	2514	270	343	46	651	87	0
50-54	5210	111	526	1454	1692	288	430	63	594	52	0
55-59	3289	110	611	901	821	168	259	39	357	21	2
60-64	1211	65	357	339	202	39	90	8	103	8	0
65-69	441	20	195	89	49	16	25	4	32	10	1
70+	328	36	183	46	22	8	15	1	16	1	0

Хүснэгт 20. Ажил эрхэлж буй хүн амыг боловсролын түвшинг сумдаар авч үзэхэд

Боловсролын түвшин	
--------------------	--

	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистр	Доктор
Бүгд	52114	1748	8481	11936	14978	1638	1872	275	10328	850	8
Мөрөн сум	13640	195	438	1166	5382	375	730	87	4795	467	5
Алаг-Эрдэнэ сум	2667	76	437	751	686	84	96	21	468	48	0
Арбулаг сум	1814	75	575	469	356	50	23	5	246	14	1
Баянзүрх сум	1873	78	525	577	339	52	39	8	238	17	0
Бүрэнтогтох сум	1920	53	408	572	477	95	41	2	253	19	0
Галт сум	2385	64	746	541	649	39	72	5	258	10	1
Жаргалант сум	2109	75	674	471	425	66	56	5	321	16	0
Их-Уул сум	1829	30	145	604	563	97	61	15	293	21	0
Рашаант сум	1572	19	181	533	474	51	62	7	218	27	0
Рэнчинлхүмбэ сум	2179	128	716	475	510	42	39	11	251	7	0
Тариалан сум	2414	34	177	706	909	62	104	19	393	10	0
Тосонцэнгэл сум	1827	22	235	729	428	41	61	12	271	28	0
Төмөрбулаг сум	1838	91	524	489	444	44	24	6	199	17	0
Түнэл сум	1585	39	305	619	323	52	32	3	202	10	0
Улаан-Уул сум	1471	167	380	278	302	36	47	4	237	19	1
Ханх сум	940	85	137	240	263	24	31	10	132	18	0
Цагааннуур сум	678	11	193	162	127	31	15	8	124	7	0
Цагаан-Уул сум	2609	141	526	720	718	100	78	13	301	12	0
Цагаан-Үүр сум	982	26	109	308	243	31	54	5	195	11	0
Цэцэрлэг сум	2061	183	475	473	401	93	73	10	320	33	0
Чандмань-Өндөр сум	1285	22	139	376	402	107	45	11	175	8	0
Шинэ-Идэр сум	1222	107	318	292	219	28	35	2	206	15	0
Эрдэнэбулган сум	1214	27	118	385	338	38	54	6	232	16	0

1.5 Ажиллах хүчнээс гадуурх хүн амын төлөв байдал

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно.

Хөвсгөл аймгийн хувьд сүүлийн 5 жилийн дунджаар ажиллах хүчнээс гадуурх хүн ам буюу эдийн засгийн идэвхгүй 28 000 иргэн байна.

График 8. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо



2020 оны хүн амын тооллогоор Хөвсгөл аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нь 36717 хүн буюу 15, түүнээс дээш насны хүн ам 40 хувийг эзэлж байна. Үүнд 15-19 насны 9371 иргэн байгаа бөгөөд тухайн насны ангиллын 91.4 хувийг эзэлж байна.

Мөн тооллогоор 5497 хүн тохирох ажил олдохгүйн улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа гэсэн дүн гарчээ. Энэ хүн амын 410 хүн буюу 12.7 хувь нь 15-24 насны залуучууд эзэлж байна.

Хүснэгт 21. Эдийн засгийн идэвхгүй хүн ам насны бүлгээр

Насны бүлэг	Эдийн засгийн идэвхгүй хүн ам	
	Бүгд	
	Хүний тоо	Хувь
БҮГД	36717	40
15-19	9371	91.4
20-24	5991	56.5
25-34	4927	22.8
35-44	3130	17.3
45-54	3195	20.5
55-59	2727	44.0
60+	7376	78.4

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг ажил эрхлэхгүй байгаа шалтгаан нөхцөлөөр ангилж үзэхэд шат шатны боловсролын байгууллагад суралцаж байгаа 15 болон түүнээс дээш насны хүн ам 14496 байгаа бөгөөд энэ нь дангаараа ажиллах хүчнээс гадуурх хүн ам буюу эдийн засгийн идэвхгүй хүн амын 40 хувийг бүрдүүлж байна. Тэтгэвэрт 9163 хүн байгаа бөгөөд энэ ангилалд 50 хүртэл насны 85 иргэн байна. Харин тохирох ажил олдохгүй 5497 хүн байгаагийн 1102 буюу 25 орчмыг нь 25-29 насны залуучууд эзэлж байгаа нь анхаарал татах үзүүлэлт юм.

Хүснэгт 22. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, насны бүлгээр

	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	36717	14496	9163	2112	3182	5497	171	2096
15-19	9371	8970	0	42	77	130	7	145

20-24	5991	4523	0	112	319	671	22	344
25-29	3037	875	0	195	554	1102	21	290
30-34	1890	92	0	201	540	771	20	266
35-39	1630	24	0	223	463	646	19	255
40-44	1500	4	26	241	369	618	24	218
45-49	1489	6	69	295	304	580	18	217
50-54	1706	1	312	343	298	548	22	182
55-59	2727	0	1706	308	207	356	16	134
60-64	2703	1	2445	110	46	70	2	29
65-69	1749	0	1714	21	4	5	0	5
70+	2924	0	2891	21	1	0	0	11

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг 15, түүнээс дээш насны хүн амд эзлэх хувийг авч үзэхэд Ханх, Улаан-Уул, Цагаан-Үүр сумд аймгийн дунджаас 7-10 хувиар өндөр байгаа бол Баянзүрх, Арбулаг, Цагаан-Уул сумд аймгийн дунджаас 9-12 хувиар доогуур байна.

Хүснэгт 23. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь сумдаар

СУМ	Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь		
	15, түүнээс дээш насны хүн ам	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	Эзлэх хувь
Бүгд	91813	36717	40
Мөрөн сум	27863	12618	45
Алаг-Эрдэнэ сум	4621	1826	40
Арбулаг сум	2685	835	31
Баянзүрх сум	2646	747	28
Бүрэнтогтох сум	2967	1015	34
Галт сум	3703	1303	35
Жаргалант сум	3786	1591	42
Их-Уул сум	2857	1001	35
Рашаант сум	2612	994	38
Рэнчинлхүмбэ сум	3367	1169	35
Тариалан сум	4282	1717	40
Тосонцэнгэл сум	2967	1041	35
Төмөрбулаг сум	2958	1031	35
Түнэл сум	2929	1159	40
Улаан-Уул сум	2930	1397	48
Ханх сум	1942	967	50
Цагааннуур сум	1288	573	44
Цагаан-Уул сум	3803	1163	31
Цагаан-Үүр сум	1888	892	47
Цэцэрлэг сум	3239	1099	34
Чандмань-Өндөр сум	2150	793	37
Шинэ-Идэр сум	2239	999	45

Эрдэнэбулган сум	2091	787	38
------------------	------	-----	----

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын боловсролыг сумдаар авч үзэхэд суурь болон бүрэн дунд боловсролтой 23930 иргэд байгаа бөгөөд энэ нь нийт ажиллах хүчнээс гадуурх иргэдийн 65 хувийг эзэлж байна. Мөрөн, Ханх сумын иргэдийн 68 хувь, Тариалан сумын иргэдийн 69 хувь, Их-Уул сумын иргэдийн 72 хувь нь суурь болон бүрэн дунд боловсролтой байна. Харин Шинэ-Идэр сумыг бусад сумтай харьцуулан үзэхэд ажиллах хүчнээс гадуурх хүн амд суурь болон бүрэн дунд боловсрол хамгийн бага буюу 55 хувийг эзэлж байгаа юм.

Дипломын дээд, бакалаврын дээд болон түүнээс дээш боловсролтой иргэд нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 8.6 хувийг эзэлж байгаа бол эдгээр ангиллыг нэгтгэсэн дүнгээр Мөрөн сум 11.9 хувь, Баянзүрх, Шинэ-Идэр сумд 9.4 хувийг эзэлж байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 6 хувийг техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой иргэд эзэлж байгаа юм. Энэ ангилалд Төмөрбулаг сум хамгийн бага буюу нийт ажиллах хүчнээс гадуурх иргэдийн 2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 24. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын боловсролын түвшин сумдаар

	Боловсролын түвшин										
	Бүгд	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн боловсролтой	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд	Бакалаврын дээд	Магистр	Доктор
Бүгд	36679	1817	5718	11077	12853	790	1257	150	2946	69	2
Мөрөн сум	12617	518	1142	2995	5637	238	584	53	1416	34	0
Алаг-Эрдэнэ сум	1825	64	254	664	561	52	74	9	142	5	0
Арбулаг сум	835	37	201	289	233	17	7	2	46	3	0
Баянзүрх сум	747	36	160	233	217	11	20	7	61	2	0
Бүрэнтогтох сум	1015	34	221	363	296	29	22	2	48	0	0
Галт сум	1303	69	259	403	430	18	23	4	92	5	0
Жаргалант сум	1556	62	378	459	474	47	33	11	90	1	1
Их-Уул сум	1001	29	116	385	339	41	32	6	51	2	0
Рашаант сум	994	58	167	331	314	20	33	4	65	2	0
Рэнчинлхүмбэ сум	1169	67	329	367	306	16	31	0	51	2	0
Тариалан сум	1717	50	247	601	588	47	76	13	94	1	0
Тосонцэнгэл сум	1040	61	189	376	297	17	28	11	58	2	1
Төмөрбулаг сум	1031	86	237	302	314	14	10	5	62	1	0
Түнэл сум	1159	52	252	428	294	25	26	2	80	0	0
Улаан-Уул сум	1397	131	317	428	386	25	17	1	90	2	0
Ханх сум	967	78	125	329	332	10	30	6	56	1	0
Цагааннуур сум	573	25	111	195	179	16	19	0	28	0	0

Цагаан-Уул сум	1163	70	200	376	378	28	34	4	71	2	0
Цагаан-Үүр сум	892	34	125	333	269	20	43	4	63	1	0
Цэцэрлэг сум	1099	101	224	324	305	32	44	1	67	1	0
Чандмань-Өндөр сум	793	37	143	271	251	30	22	0	39	0	0
Шинэ-Идэр сум	999	92	220	304	244	14	31	1	92	1	0
Эрдэнэбулган сум	787	26	101	321	209	23	18	4	84	1	0

1.6 Сурагчдын дунд хийсэн судалгааны үр дүн

2020-2021 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 ангид нийт 9019 хүүхэд суралцжээ. Сүүлийн 5 жилд ерөнхий боловсролын сургуулийг дунджаар 1570 орчим хүүхэд төгсөж байгаагаас 80 хувь нь их, дээд сургуульд дэвшин суралцаж байна. 2020 оны хүн амын тооллогоор ажиллах хүчнээс гадуурх хүн амын 40 хувь буюу 14496 хүн шат шатны боловсролын байгууллагад суралцаж байгаа бөгөөд үүний 62 хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид эзэлж байгаа юм. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд энэхүү бүлгээс нийт 2147 сурагчийг хамруулан санал асуулгын судалгааг зохион байгууллаа.

2020-2021 оны хичээлийн жилд 8-12 ангид суралцсан 9019 хүүхдийг сум тус бүрээр авч үзэхэд нийт сурагчдын 30 гаруй хувь нь Мөрөн суманд суралцаж байна. Энэ хичээлийн жилд 11-р ангид нийт 1503 хүүхэд суралцаж байсан бөгөөд 2021-2022 оны хичээлийн жилд 12 ангид дэвшин орж ирэхэд 1491 болж 12 хүүхдээр багасжээ. Хөвсгөл аймгийн хувьд ирэх 4 жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн дундаж өнгөрсөн 5 жилтэй харьцуулахад 300 хүүхдээр буюу 20 хувиар өсөх хандлага ажиглагдав.

Хүснэгт 25. 2020-2021 оны хичээлийн жилд суралцсан сурагчид сумдаар

№	Сургуулийн нэрс	Ахлах ангийн хүүхдийн тоо					
		VIII анги	IX анги	X анги	XI анги	XII анги	8-12-р анги
		Бүгд	Бүгд	Бүгд	Бүгд	Бүгд	НИЙТ
	БҮГД	2281	1998	1677	1503	1560	9019
1	Алаг-Эрдэнэ сум	43	41	20	28	22	154
2	Арбулаг сум	39	33	36	23	32	163
3	Баянзүрх сум	52	51	35	32	49	219
4	Бүрэнтогтох сум	43	43	41	33	40	200
5	Галт сум	72	94	61	71	71	369
6	Жаргалант сум	91	78	47	62	69	347
7	Их-Уул сум	106	73	45	47	65	336
8	Рашаант сум	58	44	36	37	42	217
9	Рэнчинлхүмбэ сум	65	53	48	50	49	265
10	Тариалан сум	113	92	92	63	67	427
11	Тосонцэнгэл сум	59	65	44	44	45	257
12	Түнэл сум	54	33	41	37	25	190
13	Төмөрбулаг сум	42	55	42	36	28	203
14	Улаан-Уул сум	68	55	50	64	59	296
15	Ханх сум	46	35	23	34	36	174
16	Хатгал тосгон	47	47	44	45	36	219
17	Цагаан-Уул сум	96	76	61	53	60	346

18	Цагаан-Үүр сум	31	39	29	29	40	168
19	Цагааннуур сум	39	37	33	23	24	156
20	Цэцэрлэг сум	62	62	47	43	36	250
21	Чандмань-Өндөр сум	53	31	32	36	32	184
22	Шинэ-Идэр сум	45	37	27	32	31	172
23	Эрдэнэбулган сум	41	43	30	34	32	180
24	Мөрөн сум	916	781	713	547	570	3527

Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн тоог сүүлийн 6 жилээр авч үзэхэд 2018 онд хамгийн их буюу 2181 төгссөн бол харин 2019 онд хамгийн бага буюу 680 хүүхэд төгсжээ.

2019 онд бага төгсөгчтэй байсан шалтгаан нь 2006-2007 оны хичээлийн жилд Монгол улс 12 жилийн боловсролын тогтолцоонд шилжиж 2018 хичээлийн жилд 11 жилийн сургалтын хөтөлбөр, 12 жилийн хөтөлбөрөөр зэрэг төгссөнтэй холбоотой. 2022 онд буюу ирэх онд 1491 хүүхэд ерөнхий боловсролын сургууль төгсөхөөр байна.


Хүснэгт 26. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчид сүүлийн 6 жилээр

№	Сургууль	2022	2021	2020	2019	2018	2017	2016
1	Мөрөн сумын ерөнхий боловсролын Титэм сургууль	85	81	76	58	104	61	102
2	Мөрөн сумын ерөнхий боловсролын Нутгийн аваргууд сургууль	13	23	16	14	18	19	17
3	Алаг-Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургууль	27	22	20	18	43	24	28
4	Арбулаг сумын ерөнхий боловсролын сургууль	21	32	36	17	58	52	39
5	Баянзүрх сумын ерөнхий боловсролын сургууль	31	49	41	13	57	51	70
6	Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургууль	36	40	41		41	41	25
7	Галт сумын ерөнхий боловсролын сургууль	69	71	66	18	86	70	66
8	Мөрөн сумын ерөнхий боловсролын Мөрөн Гурван-Эрдэнэ сургууль	61	51	61	41	50	56	90
9	Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургууль	147	141	141	114	151	134	183
10	Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль	62	69	60	35	103	68	93
11	Мөрөн сумын ерөнхий боловсролын Ирээдүй хорин нэгдүгээр зуун сургууль	58	46	45	22	79	82	104
12	Их-Уул сумын ерөнхий боловсролын сургууль	46	65	40	13	109	57	53
13	Рашаант сумын ерөнхий боловсролын сургууль	36	42	34	14	78	43	38
14	Рэнчинлхүмбэ сумын ерөнхий боловсролын сургууль	46	49	41	44	54	47	54
15	Тариалан сумын ерөнхий боловсролын сургууль	66	67	61	24	92	79	85
16	Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын сургууль	43	45	44		76	65	63
17	Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль	36	25	44		41	34	40

18	Төмөрбулаг сумын ерөнхий боловсролын сургууль	34	28	35	8	74	43	59
19	Мөрөн сумын Авьяас ерөнхий боловсролын сургууль	26	44	18	22	36	51	25
20	Улаан-Уул сумын ерөнхий боловсролын сургууль	67	59	51	18	103	69	73
21	Ханх сумын ерөнхий боловсролын сургууль	30	36	48	1	38	33	29
22	Хатгал тосгоны ерөнхий боловсролын сургууль	45	36	46	16	54	48	57
23	Мөрөн сумын ерөнхий боловсролын Сод-эрдэм сургууль	36	40	33	17	163	184	
24	Цагаан-Уул сумын ерөнхий боловсролын сургууль	53	60	55	26	107	62	94
25	Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургууль	27	40	33		45	31	30
26	Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургууль	22	24	16	14	41	37	34
27	Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль	42	36	48	18	56	49	67
28	Чандмань-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль	34	32	32		40	36	54
29	Шинэ-Идэр сумын ерөнхий боловсролын сургууль	33	31	30	29	36	28	38
30	Мөрөн сумын ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль	111	138	97	61	165	151	157
31	Эрдэнэбулган сумын ерөнхий боловсролын сургууль	35	32	33		55	42	39
32	Далай ван дээд сургуулийн харъяа ерөнхий боловсролын сургууль	13	6	10	5	28	34	34
	НИЙТ	1491	1560	1452	680	2281	1881	1940

Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын 32 сургуулийн 9-12 ангийн 2147 хүүхдийг хамруулсан судалгаанд 12-р ангийн нийт 722, 11-р ангийн 465, 10-р ангийн 420, 9-р ангийн 540 хүүхдийг хамруулжээ. Судалгаанд оролцогчдын 64.6 хувь нь эмэгтэй сурагч, 1978 хүүхэд нь 15-аас дээш насны хүүхэд байв.

График 9. Судалгаанд оролцсон анги бүлэг хувиар



Судалгаанд оролцсон сурагчдын 88.9 хувь нь буюу 1909 хүүхэд цаашид МСҮТ, Коллеж, Их дээд сургуульд дэвшин суралцана хэмээн хариулсан байна. Сурагчдын 76.3 хувь нь буюу 1639 сурагч мэргэжлээ сонгосон гэж хариулсан бөгөөд сурагчдыг анги бүлгээр авч үзэхэд 12-р ангийн сурагчдын 86.4 хувь нь 9 –р ангийн сурагчдын 64.8 хувь нь 10-11 ангийн сурагчийн 75 хувь нь үргэлжлүүлэн суралцах мэргэжлээ сонгожээ.

График 10. Мэргэжлээ сонгосон эсэх, анги бүлгээр




График 11. Цаашид МСҮТ, Коллеж, Их дээд сургуульд дэвшин суралцах эсэх



Мэргэжлээ сонгосон нийт 1493 сурагчийн саналыг мэргэжлийн салбар бүрээр нэгтгэн бүлэглэж үзэхэд анагаах ухаан, цэрэг цагдаа, батлан хамгаалах, боловсролын байгууллага багш, хууль эрх зүй, инженер, нийгмийн ухааны салбарууд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин сантехник, мужаан, гагнуурчин, засварчин зэрэг ажил мэргэжлүүд хамгийн бага хувийн сонголтыг авчээ.


Хүснэгт 27. Сурагчдын сонгосон мэргэжлийн чиглэл

№	Суралцах чиглэл	Сурагчдын тоо	Хувь
	НИЙТ	1493	100
1	Анагаах ухааны чиглэлээр	364	24.4
2	Цэрэг, цагдаа, батлан хамгаалах чиглэл	130	8.7
3	Багш, боловсролын чиглэл	126	8.4
4	Хууль, эрх зүйн чиглэл	125	8.4
5	Инженер чиглэлээр	120	8
6	Нийгмийн ухааны мэргэжил	87	5.8
7	Мэдээллийн технологи, программ хангамж чиглэл	75	5
8	Урлаг, соёлын салбар	58	3.9
9	Санхүү, эдийн засаг чиглэл	53	3.5
10	Олон улсын харилцаа	48	3.2
11	Бизнес маркетинг	41	2.7
12	Барилгын салбар	28	1.9

13	Нисэх онгоц, төмөр зам	25	1.7
14	Тогооч, оёдолчин	25	1.7
15	График дизайн	23	1.5
16	Шинжлэх ухааны салбар	22	1.5
17	Үсчин, гоо сайхан	20	1.3
18	Ашигт малтмал, уул уурхай	17	1.1
19	Авто механик	15	1
20	Архитектор	14	0.9
21	Удирдлага менежмент	13	0.9
22	Аялал жуулчлал	12	0.8
23	Хөдөө аж ахуй	12	0.8
24	Техник технологи	11	0.7
25	Байгаль орчин	10	0.7
26	Засварчин, мужаан	9	0.6
27	Цахилгаан, гагнуурчин	8	0.5
28	Сантехникч	2	0.1


160 сурагч цаашид Их, дээд сургууль, МСҮТ, коллежид дэвшин суралцахгүй гэжээ. Эдгээр сурагчдын хариултыг бүлэглэж үзвэл сурагчдын 22.5 хувь нь бүрэн дунд боловсролтой л байхад болно гэж үзсэн бол 11.9 хувь нь амьдралын боломж муугаас дараагийн шатны сургуульд дэвшин суралцахгүй гэжээ. Сурагчдын 8 хувь нь гадаад улс оронд явна гэсэн бол үлдсэн 31 хувь нь хэлж мэдэхгүй гэж хариулсан бол 13.7 хувь нь малчин болно, хувиараа ажил хөдөлмөр эрхэлнэ гэжээ.

График 12. Сурагчдын Их, дээд сургуульд суралцахгүй шалтгаан



Судалгаанд оролцсон сурагчдаас дараагийн шатны боловсролоо байршлын хувьд хаана суралцаж эзэмшихийг асуухад 71.2 хувь буюу 1528 сурагч Улаанбаатар хотод, 10 хувь нь гадаад улсад, 4.5 хувь нь бусад аймаг хотод, 103 сурагч буюу 4.8 хувь нь Хөвсгөл аймагтаа суралцана хэмээн хариулжээ.

График 13. Цаашид хаана суралцах эсэх



1.8 Оюутны дунд хийсэн судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд Хөвсгөл аймгийн харьяат Их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудын жагсаалтад дүн шинжилгээ хийв. Монгол Улсын Боловсрол шинжлэх ухааны яаманд Хөвсгөл аймгийн Боловсролын газраар дамжуулан хүсэлт тавьж 2020-2021 оны хичээлийн жилд суралцаж буй нийт 5096 оюутны жагсаалтыг авсан бөгөөд энэхүү нэрсийн жагсаалтад судалгааны баг бүрэлдэхүүн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ашиглаж буй E-halamj программд шүүлт хийн үндсэн харьяаллыг тогтоож ажиллалаа. Судалгааны явцад хоёр оюутан нас барсан тул 5094 оюутны мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Нийт оюутнууд хүйсийн хувьд 1737 буюу 34.1 хувь нь эрэгтэй байгаа бол 65.9 хувь нь буюу 3359 эмэгтэй оюутан байна.

Ингээд Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоноор Их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудыг суралцаж буй курсээр нь ангилан харьцуулж үзэхэд 1-р курст 1641 хүүхэд элсэн орсон бөгөөд 2-р курсийн оюутнууд 12 жилийн боловсролын тогтолцоонд шилжсэнтэй холбоотой багассан 836 оюутан суралцаж байгаа бол 3-р курст 1180, 4-р курст 1197 оюутан суралцаж байна .

Анагаах ухаан, хуулийн салбарын зарим мэргэжлийг 5-6 жилийн хугацаанд эзэмшдэг тул 5-6 курсийн оюутны тоо суралцаж буй мэргэжлийн онцлогоос хамаарч бага байгаа юм. 2020-2021 оны хичээлийн жилд Мөрөн сумаас 1785 залуу суралцаж байгаа бол Галт, Цагаан-Уул, Тариалан, Жаргалант, Их-Уул сумдаас суралцаж буй оюутны тоо бусад сумдаас өндөр. 2020-2021 оны хичээлийн жилд 2-р курст байгаа оюутнууд 2022-2023 оны хичээлийн жилд 4 курст орох бөгөөд 2023 онд Их, дээд сургууль төгсөгчдийн тоо бусад жилүүдээс илт бага байхаар байна.

Хүснэгт 28. Оюутнууд суралцаж буй курс болон сумдаар

№	Үндсэн харьяалал	Курс						БҮГД
		1-р курс	2-р курс	3-р курс	4-р курс	5-р курс	6-р курс	
1	Алаг-Эрдэнэ	39	15	23	20	3	6	106
2	Арбулаг	32	19	32	31	3	1	118
3	Баянзүрх	39	38	31	36	3	2	149
4	Бүрэнтогтох	66	19	31	42	4	2	164
5	Галт	83	30	46	64	10	4	237
6	Жаргалант	42	28	46	54	10	4	184
7	Их-Уул	48	29	58	37	9	3	184
8	Мөрөн	697	275	360	363	59	31	1785
9	Рашаант	30	23	49	35	3	2	142

10	Рэнчинлхүмбэ	31	27	19	24	6	3	110
11	Тариалан	57	30	43	57	10	2	199
12	Тосонцэнгэл	27	25	40	50	3	2	147
13	Төмөрбулаг	52	23	44	42	2	4	167
14	Түнэл	34	12	31	33	2	1	113
15	Улаан-Уул	42	18	45	36	4	1	146
16	Ханх	18	12	15	13	0	0	58
17	Хатгал	19	17	23	37	2	0	98
18	Цагаан-Уул	57	44	47	51	8	4	211
19	Цагаан-Үүр	26	12	29	21	1	1	90
20	Цагааннуур	30	6	12	6	2	0	56
21	Цэцэрлэг	54	21	31	45	6	0	157
22	Чандмань-Өндөр	21	6	25	20	4	0	76
23	Шинэ-Идэр	23	19	21	20	4	0	87
24	Эрдэнэбулган	27	6	18	22	2	0	75
25	Тодорхойгүй	47	82	61	38	6	1	235
	НИЙТ	1641	836	1180	1197	166	74	5094

Хөвсгөл аймгийн харьяат 5094 оюутан 237 мэргэжлийн чиглэлээр суралцаж байна. Эрх зүй, анагаах ухаан, нягтлан бодох бүртгэл, цэцэрлэгийн багш, бага ангийн багш, сувилагч, санхүү, барилгын инженер, бизнесийн удирдлага зэрэг мэргэжлүүдээр хамгийн олон оюутан суралцаж байгаа юм. Нийтлэг 50 чиглэлээр нийт суралцагчдын 78.6 хувь буюу 4007 нь суралцаж байна.

Хүснэгт 29. Суралцаж буй мэргэжил /Курсээр/

№	Мэргэжлийн чиглэлүүд	Курс						НИЙТ
		1-р курс	2-р курс	3-р курс	3-р курс	5-р курс	6-р курс	
1	БҮГД	1641	836	1180	1197	166	74	5094
2	Эрхзүй	104	85	90	105	7	0	391
3	Анагаах ухаан	54	44	57	62	40	40	297
4	Нягтлан бодох бүртгэл	81	31	53	50	2	0	217
5	Багш, сургуулийн өмнөх насны боловсрол	77	23	27	51	1	0	179
6	Багш, бага ангийн боловсрол	48	25	47	54	0	0	174
7	Сувилахуй	47	12	40	41	2	0	142
8	Санхүү	48	16	36	33	0	0	133
9	Барилгын инженер	37	17	25	37	5	5	126
10	Нүүр ам судлал	31	11	39	25	16	4	126
11	Бизнесийн удирдлага	46	26	15	30	1	1	119
12	Боловсролын удирдлага	76	39	0	0	0	0	115
13	Эм зүй	16	9	27	33	30	0	115
14	Эдийн засаг	20	23	31	22	0	0	96
15	Багш, гадаад хэлний боловсрол	29	11	31	21	0	0	92
16	Нийгмийн ажил	53	12	14	12	0	0	91
17	Менежмент	18	9	22	37	3	0	89
18	Боловсрол судлал	43	35	3	0	0	0	81

19	Багш, байгалийн ухааны боловсрол	19	11	20	24	0	0	74
20	Багш, нийгмийн ухааны боловсрол	23	10	22	18	0	0	73
21	Цахилгааны инженер	19	13	28	9	2	0	71
22	Багш, биеийн тамирын боловсрол	16	11	20	21	0	0	68
23	Багш, урлагийн боловсрол	17	15	15	21	0	0	68
24	Уламжлалт анагаах ухаан	14	5	11	16	11	11	68
25	Багш, математикийн боловсрол	14	8	22	23	0	0	67
26	Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	22	8	15	13	0	0	58
27	Програм хангамж	12	16	10	17	0	0	55
28	Цахилгаан хангамж	11	13	12	15	0	1	52
29	Гадаад хэлний орчуулга	15	9	14	10	1	1	50
30	Сэтгэл судлал	27	15	6	2	0	0	50
31	Инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл	45	0	0	0	0	0	45
32	Механик инженер	12	4	12	16	0	0	44
33	Төрийн удирдлага	13	7	11	11	0	0	42
34	Олон улсын харилцаа	11	7	15	8	0	0	41
35	Архитектур	10	4	7	13	2	2	38
36	Сэтгүүл зүй	4	11	10	12	0	0	37
37	Дулааны инженер	8	4	15	7	1	1	36
38	Маркетинг	15	1	7	13	0	0	36
39	Аюулгүй байдал - хууль сахиулах	8	2	12	12	0	0	34
40	График дизайн	11	9	3	5	3	2	33
41	Нийгмийн эрүүл мэнд	17	6	2	3	5	0	33
42	Мал эмнэлзүй	6	2	6	9	9	0	32
43	Бизнес ба удирдахуй	31	0	0	0	0	0	31
44	Авто инженер	6	6	9	9	0	0	30
45	Хүрээлэн буй орчны инженер	10	3	10	3	3	1	30
46	Аялал жуулчлал	7	6	12	2	0	0	27
47	Хүмүүнлэг	27	0	0	0	0	0	27
48	Газар зохион байгуулалт (төлөвлөлт, кадастр)	6	7	7	5	0	0	25
49	Уул уурхайн ашиглалтын технологи	3	5	9	7	1	0	25
50	Мэдээллийн систем	5	1	7	10	1	0	24

Хөвсгөл аймгаас 5094 оюутан нийт 81 Их, дээд сургуульд суралцаж байна. Хамгийн олон оюутан суралцаж буй 20 сургуулийг оюутны тоогоор эрэмбэлэн үзэхэд МУБИС, МУИС, ШУТИС эхний 3 байранд эрэмбэлэгдэж байгаа бол орон нутагтаа мэргэжилтэн бэлтгэж буй ганц сургууль болох Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Далай ван дээд сургууль 20-рт эрэмбэлэгдэж байна.

Далай ван дээд сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд 43 оюутан суралцаж байгаагаас 28 оюутан нь 2021 онд төгсөхөөр байгаа бөгөөд 1-3-р курст 15 оюутан суралцаж байна. Энэхүү 20 сургуульд нийт суралцагчдын 85 хувь нь буюу 4331 оюутан суралцаж байна


Хүснэгт 30. Суралцаж буй сургууль, курсээр

№	Сургуулийн нэр	КУРС						Бүгд
		1-р курс	2-р курс	3-р курс	4-р курс	5-р курс	6-р курс	
1	МУБИС /Монгол улсын боловсролын их сургууль/	191	138	178	160	1	0	668
2	МУИС /Монгол улсын их сургууль/	276	129	124	109	6	0	644
3	ШУТИС /Шинжлэх ухаан технологийн их сургууль/	126	72	147	104	32	19	500
4	МУИС /Монголын үндэсний их сургууль/	24	111	89	152	10	0	386
5	АШУҮИС /Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль/	130	56	57	73	34	24	374
6	ХААИС /Хөдөө аж ахуйн их сургууль/	49	35	126	96	9	0	315
7	Этүгэн их сургууль	81	25	80	73	37	16	312
8	ИЗОУИС /Их засаг олон улсын их сургууль/	76	26	86	81	0	0	269
9	Глобал удирдагч их сургууль	72	23	5	3	1	2	106
10	СУИС /Соёл урлагийн их сургууль/	20	12	27	36	0	0	95
11	ҮБХИС /Үндэсний батлан хамгаалахын их сургууль/	13	19	34	25	2	0	93
12	Идэр их сургууль	32	10	7	29	0	0	78
13	ДХИС /Дотоод хэргийн их сургууль/	31	15	7	17	2	0	72
14	Ач анагаах ухааны их сургууль	7	14	19	17	5	7	69
15	Улаанбаатар эрдэм их сургууль	58	4	4	2	1	0	69
16	ХУИС /Хүмүүнлэгийн ухааны их сургууль/	18	8	18	19	0	0	63
17	Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль	2	2	20	17	17	3	61
18	Маргад дээд сургууль	45	1	1	10	0	0	57
19	Санхүү, эдийн засгийн их сургууль	51	5	1	0	0	0	57
20	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Далай ван дээд сургууль	5	5	5	28	0	0	43
БҮГД		1307	710	1035	1051	157	71	4331

Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд Их, дээд сургуульд суралцаж байгаа 5094 оюутны дунд 1053 оюутныг хамруулан санал асуулгын судалгааг зохион байгууллаа.


Судалгаанд хамрагдсан оюутнуудын 720 буюу 68.6 хувь нь эмэгтэй, 231 буюу 21.9 хувь нь Мөрөн сумын үндсэн харьяалалтай оюутнууд байна. Нийт судалгаанд оролцогчдоос 1-р курсийн 346, 2-р курсийн 148, 3-р курсийн 253, 4-р курсийн 252 оюутан хамрагдав.

График 14. Судалгаанд оролцсон оюутнууд курс, хувиар



Их, сургуулиа төгсөөд хаана ажиллах төлөвлөгөөтэй байна гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 63 буюу 6 хувь нь өөрийн төрсөн сумандаа, 270 буюу 25.6 хувь нь аймгийн төв Мөрөн хотод, 484 буюу 46 хувь нь Улаанбаатар хотод, 8.1 хувь нь гадаадад амьдарна гэсэн бол үлдсэн 14.3 хувь нь бусад аймаг хотод амьдарна гэж хариулжээ.

График 15. Төгсөөд хаана ажиллаж амьдрах сонирхолтой вэ?



Төгсөөд хаана ажиллаж амьдрах сонирхолтой эсэхийг сумдаар харьцуулж үзвэл Мөрөн сумын үндсэн харьяалалтай нийт 231 оюутан хамрагдсаны 80 оюутан нь аймгийн төвдөө ажиллаж амьдарна гэжээ. Улаан-Уул сумаас судалгаанд хамрагдсан оюутнуудын нэг нь ч нутагтаа ажиллаж амьдарна гэж хариулаагүй бол 91 оюутан хамрагдсан Бүрэнтогтох сумаас зөвхөн 1 оюутан өөрийнхөө суманд ирж ажиллаж амьдарна гэсэн бол 28 оюутан аймгийн төвд ажиллана хэмээн хариулсан байна.

Хүснэгт 31. Төгсөөд хаана ажиллаж амьдрах эсэх /Сумдаар/

№	Сумд	Та төгсөөд хаана ажиллаж амьдрах вэ?					БҮГД
		Хөвсгөл аймгийн төвд	Өөрийн сумандаа	Улаанбаатар	Бусад аймаг хотод	Гадаад улсад	
1	Алаг-Эрдэнэ сум	12	2	12	2	5	33
2	Арбулаг сум	7	2	9	3	1	22
3	Баянзүрх сум	15	3	14	13	1	46
4	Бүрэнтогтох сум	28	1	43	13	6	91
5	Галт сум	12	5	12	2	2	33
6	Жаргалант сум	15	6	34	8	3	66
7	Их-Уул сум	2	1	14	1	3	21

8	Мөрөн сум	78	2	116	13	22	231
9	Рашаант сум	14	11	15	6	4	50
10	Рэнчинлхүмбэ сум	1	1	3	3	2	10
11	Тариалан сум	4	2	13	8	2	29
12	Тосонцэнгэл сум	4	1	16	5	3	29
13	Төмөрбулаг сум	8	3	17	5	2	35
14	Түнэл сум	4	1	9	7	3	24
15	Улаан-Уул сум	7	0	11	3	1	22
16	Ханх сум	5	3	9	3	0	20
17	Хатгал тосгон	9	1	11	6	7	34
18	Цагаан-Уул сум	16	4	20	10	7	57
19	Цагаан-Үүр сум	10	4	26	10	3	53
20	Цагааннуур сум	0	1	6	5	1	13
21	Цэцэрлэг сум	7	4	30	6	4	51
22	Чандмань-Өндөр сум	5	1	10	7	0	23
23	Шинэ-Идэр сум	5	1	15	6	1	28
24	Эрдэнэбулган сум	2	3	19	6	2	32
НИЙТ		270	63	484	151	85	1053

Мөн судалгаанд оролцсон оюутнуудын цаашдын төлөвлөгөөг асуухад 79.3 хувь нь мэргэжлээрээ ажиллах сонирхолтой, 33.4 хувь нь цаашид мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцах сонирхолтой, 11.1 хувь нь цаашид өөр мэргэжлээр үргэлжлүүлэн сурах сонирхолтой, 19.2 хувь нь гадаад улс руу явж ажиллах сонирхолтой, 27.4 хувь нь гадаад улсад суралцах сонирхолтой гэжээ.

Төгсөөд өмчлөлийн хувьд аль салбарт ажиллах талаар нийт судалгаанд оролцогчдын 68.5 хувь нь төрийн байгууллагад ажиллах сонирхолтой гэж хариулсан бол 34.9 хувь нь хувийн хэвшилд ажиллана хэмээн хариулжээ.

Та суралцаж байгаа мэргэжилдээ сэтгэл ханамжтай байна уу? гэсэн асуултад оюутнуудын 78.9 хувь нь сэтгэл ханамжтай гэсэн хариултыг өгчээ. 14.9 хувь нь дунд зэрэг, 6.2 хувь нь сэтгэл ханамжгүй хэмээн хариулсан байна.

1.9 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид, төгсөгчдийн дунд хийсэн судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь 1973 онд байгуулагдсанаас хойш 48 жилийн хугацаанд нийт 12000 гаруй мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлжээ.

Аймгийн МСҮТ-д 2021-2022 оны хичээлийн жилд нийт 567 суралцагч байгаа бөгөөд үндсэн харьяаллаар авч үзэхэд бусад аймаг хотоос ирж суралцаж байгаа 36 сурагч байгаа нь нийт суралцагчдын 6.3 хувийг эзэлж байна. Үлдсэн 531 суралцагч буюу 93.7 хувь нь Хөвсгөл аймгаасаа суралцаж байгаа бөгөөд энэхүү бүтцээс харахад Хөвсгөл аймгийн МСҮТ нь аймгийнхаа боловсон хүчнийг голлон бэлддэг үндсэн суурь бааз хэмээн дүгнэж болохоор байгаа юм. Мөн Мөрөн сумтай хамгийн ойр байрладаг Арбулаг, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Түнэл сумаас суралцагчдын тоо бусад сумдаас илүү өндөр байна.

Хүснэгт 32. МСҮТ-д суралцагчдын тоо сумдаар

№	Сум	Суралцагчийн тоо	Суралцагчийн хувь
1	Алаг-Эрдэнэ	16	2.8

2	Арбулаг	36	6.3
3	Баянзүрх	17	3
4	Бүрэнтогтох	31	5.5
5	Галт	14	2.5
6	Жаргалант	10	1.8
7	Их-Уул	4	0.7
8	Мөрөн	155	27.3
9	Рашаант	6	1.1
10	Рэнчинлхүмбэ	21	3.7
11	Тариалан	9	1.6
12	Тосонцэнгэл	21	3.7
13	Төмөрбулаг	37	6.5
14	Түнэл	29	5.1
15	Улаан-Уул	11	1.9
16	Ханх	8	1.4
17	Хатгал	7	1.2
18	Цагаан-Уул	30	5.3
19	Цагаан-Үүр	13	2.3
20	Цагааннуур	6	1.1
21	Цэцэрлэг	9	1.6
22	Чандмань-Өндөр	17	3
23	Шинэ-Идэр	17	3
24	Эрдэнэбулган	7	1.2
25	Бусад	36	6.3
	НИЙТ	567	100

МСҮТ нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 21 чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд үүнээс тогооч, засварчин, оёдолчин, барилгын засал чимэглэлч, сантехникч, гоо засалч, үсчин, цахилгаанчин, гагнуурчин зэрэг мэргэжлүүдээр хамгийн олон элсэгч суралцаж байна. Сурагчдаас авсан судалгаагаар хамгийн бага сонгогдож байгаа болон аймгийн хөдөлмөрийн насны хүн амыг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд хамгийн бага байгаа энэхүү мэргэжлүүд МСҮТ дээр илүү олон элсэгчтэй байгаа нь хөдөлмөрийн зах зээлд тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлэхүйц үзүүлэлт болж байна.

Хүснэгт 33. 2021-2022 онд МСҮТ-д суралцаж буй суралцагчид мэргэжлийн ангиар

№	Сум	Суралцагчдын тоо	Суралцагчдын хувь
1	Тогооч	71	12.5
2	Автомашин засварчин	64	11.3
3	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	60	10.6
4	Барилгын засал чимэглэлч	46	8.1
5	Барилгын сантехникч	43	7.6
6	Гоо засалч	32	5.6
7	Үсчин	29	5.1
8	Барилгын цахилгаанчин	26	4.6
9	Гагнуурчин	25	4.4
10	Модон эдлэлийн мужаан	23	4.1

10	Рэнчинлхү мбэ	1	2	1	0	0	1	0	0	0	1	1	1	1	6	2	0	0	4	0	0	0	21
11	Тариалан	1	0	1	0	2	0	1	0	0	0	0	0	0	2	0	1	0	1	0	0	0	9
12	Тосонцэнгэл	2	1	2	0	4	0	1	0	0	0	1	1	0	2	0	0	0	3	2	0	2	21
13	Төмөрбулаг	5	0	5	0	0	2	2	0	2	5	0	2	2	4	2	0	1	3	1	1	0	37
14	Түнэл	4	1	4	2	2	1	0	0	3	0	0	2	1	3	1	0	1	3	1	0	0	29
15	Улаан-Уул	1	0	2	0	1	0	1	0	0	0	0	1	0	2	0	0	1	2	0	0	0	11
16	Ханх	0	3	0	0	1	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	2	0	0	0	8
17	Хатгал	0	0	1	0	2	0	1	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	1	7
18	Цагаан-Уул	4	1	3	1	2	0	0	0	1	5	1	2	0	7	0	0	0	2	1	0	0	30
19	Цагаан-Үүр	0	0	1	1	1	0	0	0	0	2	0	0	1	1	0	1	0	5	0	0	0	13
20	Цагааннуур	0	0	0	0	0	0	0	0	1	0	2	3	0	0	0	0	0	0	0	0	0	6
21	Цэцэрлэг	0	0	0	0	2	0	0	0	1	1	0	0	1	3	0	0	1	0	0	0	0	9
22	Чандмань-Өндөр	2	0	1	0	2	2	1	1	0	1	1	1	0	1	0	0	0	2	2	0	0	17
23	Шинэ-Идэр	2	0	0	0	1	0	1	0	1	1	0	1	0	0	0	0	2	3	2	2	1	17
24	Эрдэнэбулган	2	0	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	0	1	0	7
25	Бусад	5	1	0	0	2	0	2	1	2	4	2	2	0	2	2	0	0	5	2	1	3	36
	Нийт	64	19	46	12	43	18	26	15	25	32	16	23	13	60	11	7	10	71	29	13	14	567

Судалгааны хүрээнд МСҮТ-д суралцаж байгаа 567 суралцагчийн 287 хамруулан санал асуулгын судалгааг зохион байгууллаа. Энэхүү судалгаанд 50.5 хувь нь буюу 145 эмэгтэй, 49.5 хувь буюу 142 эрэгтэй суралцагч хамрагдсан бол судалгаанд оролцогчдын 42.2 хувь буюу 121 суралцагч нь Мөрөн сумын харьяалалтай байна.

Мөн судалгаанд оролцогчдын 214 буюу 74.6 хувь нь 2.5 жилийн ангид суралцаж байгаа бол 25.4 хувь нь нэг жилийн ангид суралцаж байна.


“Та сургуулиа төгсөөд юу хийх төлөвлөгөөтэй байна” гэсэн асуултад МСҮТ-д суралцагчдын 8.5 хувь нь буюу 168 хүн мэргэжлээрээ ажиллана, 20.6 хувь нь цаашид Их, дээд сургууль, коллежид элсэн суралцана, 17.1 хувь нь хараахан шийдээгүй байна, 3.5 хувь нь гадаад улсад ажиллаж суралцана гэсэн хариултыг сонгожээ.

График 16. МСҮТ төгсөөд юу хийх төлөвлөгөөтэй байгаа эсэх



Та сургуулиа төгсөөд хаана ажиллах сонирхолтой байна гэсэн асуултад 48.1 хувь нь аймгийн төв Мөрөн суманд ажиллана хэмээн хариулсан бол 27.5 хувь нь Улаанбаатар хотод ажиллана 6.6 хувь нь өөрийн сумандаа очиж ажиллана гэсэн хариултыг өгчээ.

График 17. Төгсөөд хаана ажиллаж амьдрах вэ?



Та сургуулиа төгсөөд ямар байгууллагад ажилд орох хүсэлтэй байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 28.9 хувь нь төрийн байгууллагад, 27.2 хувь нь хувийн хэвшилд ажилд орох хүсэлтэй гэсэн бол 43.9 хувь нь өөрөө өөртөө ажлын байр бий болгож хувиараа хөдөлмөр эрхэлнэ гэж хариулжээ.

График 18. Та сургуулиа төгсөөд ямар байгууллагад ажилд орох хүсэлтэй байна вэ?



Хаана ажиллаж амьдрах эсэхийг сумдаар нь харьцуулж үзэхэд Мөрөн сумын үндсэн харьяалалтай 121 суралцагчдын 75 нь Мөрөн суманд, 27 нь Улаанбаатар хотод ажиллаж амьдарна гэж хариулжээ. Харьцуулсан дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 13 нь сумандаа буцан очиж ажиллаж амьдрахгүй хэмээн хариулт өгчээ.


Хүснэгт 35. Төгсөөд хаана ажиллаж амьдрах эсэх сумдаар

	Бусад газар	Мөрөн хотод	Өөрийн төрсөн сумандаа	Улаанбаатар хотод	БҮГД
Алаг-Эрдэнэ сум	1	3	1	4	9
Арбулаг сум	0	11	0	4	15
Баянзүрх сум	1	0	0	1	2
Бусад газраас	1	2	1	4	8
Бүрэнтогтох сум	2	9	0	3	14
Галт сум	3	2	0	2	7
Жаргалант сум	0	4	1	1	6
Их-Уул сум	0	2	1	1	4
Мөрөн сум	19	70	5	27	121
Рашаант сум	0	0	0	2	2
Рэнчинлхүмбэ сум	2	1	0	2	5
Тариалан сум	0	1	0	3	4
Тосонцэнгэл сум	0	4	1	2	7
Төмөрбулаг сум	3	6	1	7	17
Түнэл сум	2	5	2	4	13
Улаан-Уул сум	2	1	1	1	5
Ханх сум	0	0	0	2	2
Хатгал тосгон	1	1	0	0	2
Цагаан-Уул сум	5	5	2	1	13

Цагаан-Үүр сум	3	0	0	0	3
Цагааннуур сум	0	0	1	2	3
Цэцэрлэг сум	1	6	0	1	8
Чандмань-Өндөр сум	1	1	2	3	7
Шинэ-Идэр сум	3	2	0	1	6
Эрдэнэбулган сум	1	2	0	1	4
НИЙТ	51	138	19	79	287

Хөвсгөл аймгийн МСҮТ-ийн төгсөгчдийг сүүлийн 6 жилийн байдлаар авч үзэхэд нийт 1235 хүн мэргэжил эзэмшиж төгссөн байна. Суралцаж төгссөн иргэдийн 517 нь буюу 41.9 хувь нь эмэгтэй, 718 буюу 58.1 хувь нь эрэгтэй байна. 2016-2020 оны төгсөлтийг авч үзэхэд 2018 онд 296 суралцагч төгссөн бол 2017 онд 275 суралцагч, 2016 онд 268 суралцагч, 2020 онд 173 суралцагч тус тус төгссөн бол 2021 оны 6 сард 85 суралцагч төгсжээ.

График 19. Сүүлийн 6 жилийн Хөвсгөл аймгийн МСҮТ-ийн төгсөлт, үзүүлэлт хувиар (2021 оны хаврын төгсөлтийг оруулав)



Хөвсгөл аймгийн МСҮТ-д сүүлийн 6 жилд суралцагчдыг сумдаар авч үзэхэд нийт төгсөгчдийн 94.9 хувь нь Хөвсгөл аймгаас элсэн суралцажээ. Мөрөн сумаас элсэгчид 21.8 хувийг эзэлж байгаа бол Төмөрбулаг сум 6.6 хувь, Цагаан-Уул сум 6.2 хувь, Түнэл сум 5 хувь, Арбулаг Галт сумд тус тус 4 хувь, Тариалан сум хамгийн бага элсэлттэй буюу сүүлийн 6 жил ердөө 13 хүүхэд суралцаж төгссөн байна.

Хүснэгт 36. Сүүлийн 6 жилд МСҮТ-ийг төгсөгчид сумдаар

№	Сум	Суралцагчдын тоо	Суралцагчдын хувь
1	Алаг-Эрдэнэ	46	3.7
2	Арбулаг	50	4.0
3	Баянзүрх	42	3.4
4	Бүрэнтогтох	41	3.3
5	Галт	50	4.0
6	Жаргалант	35	2.8
7	Их-Уул	30	2.4
8	Мөрөн	269	21.8
9	Рашаант	28	2.3
10	Рэнчинлхүмбэ	29	2.3
11	Тариалан	13	1.1
12	Тосонцэнгэл	32	2.6
13	Төмөрбулаг	82	6.6
14	Түнэл	62	5.0
15	Улаан-Уул	32	2.6
16	Ханх	15	1.2
17	Хатгал	21	1.7

18	Цагаан-Уул	76	6.2
19	Цагаан-Үүр	39	3.2
20	Цагааннуур	17	1.4
21	Цэцэрлэг	40	3.2
22	Чандмань-Өндөр	52	4.2
23	Шинэ-Идэр	39	3.2
24	Эрдэнэбулган	32	2.6
25	Бусад	63	5.1
26	НИЙТ	1235	100.0

МСҮТ-ийн төгсөгчдийг сүүлийн 6 жилээр эзэмшсэн мэргэжлээр гаргаж үзэхэд нийт 25 мэргэжлийн 1235 хүнээс оёдолчин, барилгын засал чимэглэлч, автомашины засварчин, барилгын сантехникч, тогооч, ойжуулагч гэсэн 6 мэргэжил нийт төгсөгчдийн 51 хувийг эзэлж байна.

Хүснэгт 37. Сүүлийн 6 жилд МСҮТ-ийн төгсөгчид мэргэжлээр

№	Эзэмшсэн мэргэжил	Төгсөгчдийн тоо	Төгсөгчийн хувь
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	117	9.5
2	Барилгын засал чимэглэлч	116	9.4
3	Автомашины засварчин	113	9.2
4	Барилгын сантехникч	106	8.6
5	Тогооч	100	8.1
6	Ойжуулагч	77	6.2
7	Үсчин	76	6.2
8	Гагнуурчин	63	5.1
9	Гар урлалын ажилтан	59	4.8
10	Модон эдлэлийн мужаан	48	3.9
11	Ойн аж ахуйн ажилтан	48	3.9
12	Барилгын цахилгаанч	44	3.6
13	Барилгын өрөг угсрагч	42	3.4
14	Талх нарийн боовны үйлвэрийн технологи	42	3.4
15	Гоо засалч	33	2.7
16	Хүнсний ногооны фермер	28	2.3
17	Бетон арматурчин	25	2.0
18	Аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан	24	1.9
19	Нарийн бичгийн дарга-албан хэргийн ажилтан	24	1.9
20	Бэлэг дурсгалын зүйл урлаач	16	1.3
21	Сийлбэрчин	11	0.9
22	Хүлэмжийн аж ахуйн фермер	9	0.7
23	Ой арчилгаа, ашиглалтын ажилтан	6	0.5
24	Мод бэлтгэлийн ажилтан	5	0.4
25	Цахим тоног төхөөрөмжийн ажилтан	3	0.2
	НИЙТ	1235	100.0

Хүснэгт 38. Сүүлийн 6 жилд төгссөн МСҮТ-ийн төгсөгчдийг сумдаар харьцуулав


МЭРГЭЖИЛ	Алаг-Эрдэнэ	Арбулаг	Баянзүрх	Бүрэнгогтох	Галт	Жаргалант	Их-Уул	Мөрөн	Рашаант	Рэнчинлхүмбэ	Гариадан	Тосонцэнгэл	Төмөрбулаг	Түвэл	Улаан-Уул	Ханх	Хатгал	Цагаан-Уул	Цагаан-Уур	Цагааннуур	Цэцэрлэг	Чандмань-Өндөр	Шинэ-Идэр	Эрдэнэбулган	Бусад	НИЙТ
Автомашин ы засварчин	4	4	0	2	3	1	5	29	5	4	0	7	6	4	2	1	0	5	1	0	8	3	4	3	12	112
Аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан	2	1	0	0	0	0	1	6	0	1	0	0	2	1	0	2	2	0	2	0	0	0	3	0	1	24
Барилгын засал чимэглэлч	8	0	3	3	7	5	1	25	2	4	0	2	10	7	3	2	1	7	0	1	2	4	7	9	3	116
Барилгын өрөг угсрагч	1	2	3	1	0	0	3	11	1	1	0	0	3	1	1	0	0	3	0	0	1	4	2	2	2	42
Барилгын сантехникч	4	10	1	8	3	2	4	32	1	0	2	1	5	4	4	0	0	6	2	0	5	2	3	0	7	106
Барилгын цахилгаанч	0	1	1	1	0	1	3	11	3	1	3	2	5	2	1	0	0	3	1	0	2	0	0	0	3	44
Бетон арматурчин	0	1	0	1	2	0	0	4	0	1	0	0	3	8	0	1	0	0	1	0	0	0	2	0	1	25
Бэлэг дурсгалын зүйл урлаач	2	0	1	1	0	0	0	3	0	0	0	0	1	1	1	0	1	0	1	0	0	2	1	1	0	16
Гагнуурчин	1	2	2	5	2	0	2	20	1	2	1	0	2	2	3	1	3	4	0	0	2	1	3	0	4	63
Гар урлалын ажилтан	4	2	5	1	6	0	3	11	2	1	0	0	5	2	0	0	0	5	3	1	2	2	1	1	2	59
Гоо засалч	0	5	1	1	0	0	2	4	1	0	2	1	4	4	1	0	0	2	1	1	1	1	1	0	0	33
Мод бэлтгэлийн ажилтан	0	0	1	0	0	1	0	0	0	1	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	5
Модон эдлэлийн мужаан	1	4	3	0	3	1	2	12	2	0	0	1	4	2	1	0	0	3	2	2	0	0	0	4	1	48
Нарийн бичгийн дарга-албан хэргийн ажилтан	1	1	1	0	2	1	0	6	0	0	1	0	2	1	0	1	0	1	1	1	2	1	0	0	1	24
Оёмол бүтээгдэхүүн ий оёдолчин	2	5	4	4	6	9	3	22	2	3	1	4	7	9	3	1	1	8	4	5	2	1	3	3	5	117
Ой арчилгаа, ашиглалтын ажилтан	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	1	0	0	1	1	0	1	6
Ойжуулагч	6	3	4	3	3	5	0	18	1	4	0	0	5	0	3	0	2	5	2	2	2	3	1	2	3	77
Ойн аж ахуйн ажилтан	1	0	0	0	1	0	0	4	0	0	1	0	0	1	1	0	11	0	6	0	0	20	0	0	2	48
Сийдбэрчин	0	0	0	0	1	0	0	3	0	0	0	0	1	0	0	0	0	1	2	0	0	0	0	3	0	11
Талх нарийн боовны үйлвэрийн технологи	2	1	3	2	2	1	0	5	1	1	0	1	4	0	2	0	0	6	3	1	2	2	0	0	3	42
Тогооч	4	2	4	4	3	2	0	14	1	4	1	10	7	7	3	5	0	6	3	3	5	2	2	2	6	100
Үсчин	2	4	2	2	3	5	1	15	4	1	1	3	4	3	2	0	0	10	2	0	3	2	1	1	5	76
Хүлэмжийн аж ахуйн фермер	1	2	0	1	1	0	0	1	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	2	0	0	9
Хүнсний ногооны фермер	0	0	2	1	2	1	0	11	1	0	0	0	1	2	0	0	0	1	1	0	1	1	2	0	1	28
Цахим тоног төхөөрөмж ийн ажилтан	0	0	0	0	0	0	0	2	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	3
НИЙТ	46	50	42	41	50	35	30	269	28	29	13	32	82	63	32	15	21	76	39	17	40	52	39	32	63	1235

Судалгааны хүрээнд Хөвсгөл аймгийн МСҮТ-ийн төгсөгчдөөс санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулж судаллаа. Энэхүү санал асуулгад тухайн МСҮТ-ийн 2014-2021 оны нийт 135 төгсөгч хамрагдсан. Үүний 54.1 хувь нь эмэгтэй 45.9 хувь нь эрэгтэй байгаа бол 47.4 хувь нь Мөрөн сумын үндсэн харьяалалтай иргэд байна.

Судалгаанд оролцсон иргэдийн 17.3 хувь нь одоогоор ажил эрхлээгүй байгаа бол, 16.7 хувь нь үргэлжлүүлэн суралцаж байна. Үлдсэн 62 хувь нь ямар нэгэн ажил хөдөлмөр эрхэлж байгаа гэж хариулсан бол 4 хувь нь гэртээ хүүхдээ асарч байна гэжээ.

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдийг аль салбарт ажиллаж байгааг асуухад 50.4 хувь нь хувийн хэвшилд ажиллаж байгаа бол 34.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж, 14.8 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байна гэсэн хариултыг өгчээ.

График 20. МСҮТ-ийн төгсөгчдийн төлөв



Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 59.3 хувь нь мэргэжлээрээ ажиллаагүй 40.7 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна гэсэн хариултыг өгчээ. Үүнийг суралцаж төгссөн мэргэжлээр харьцуулан судалж үзэхэд судалгаанд оролцсон ойн аж ахуй мэргэжилтэй 21 иргэнээс зөвхөн 1 л хүн мэргэжлээрээ ажиллаж байна. Барилгын салбар болон оёдлын мэргэжлээр төгссөн иргэд мэргэжлээрээ илүүтэй ажиллаж байгаа байдал ажиглагдлаа.


Хүснэгт 39. Эзэмшсэн мэргэжил, ажиллаж байгаа эсэх

№	Суралцаж төгссөн мэргэжил	Та суралцаж төгссөн мэргэжлээрээ ажиллаж байгаа юу?		
		Гийм	Үгүй	Бүгд
1	Авто машины засварчин	8	3	11
2	Барилгын засал чимэглэлч	10	3	13
3	Барилгын өрөг угсрагч	8	5	13
4	Барилгын цахилгаанчин	3	15	18
5	Бэлэг дурсгалийн зүйл урлаач	2	2	4
6	Гоо засалч	0	2	2
7	компьютерын оператор албан хэргийн ажилтан	1	4	5
8	Оёдолчин	5	0	5
9	Ойн аж ахуйн ажилтан	1	20	21
10	Талх нарийн боовны ажилтан	6	11	17
11	Тогооч	9	13	22
12	Үсчин	2	2	4
13	НИЙТ	55	80	135

1.10 Ажилгүй иргэдийн дунд хийсэн судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг⁶ сүүлийн хоёр жилээр авч үзэхэд 2019 онд 7430 хүн байсан бол 2020 онд 7864 болж өсчээ. 2020 онд 7 хоногт хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн буюу ажилгүй хүн 4910, цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд боломжит ажиллах хүч 2428, хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа ажиллах хүч 526 хүн байна.


График 21. Хөдөлмөрийн дутуу ашиглалт



Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны 1218 ажилгүй иргэнээс санал асуулгын судалгааг зохион байгууллаа. Нийт судалгаанд оролцогчдын 635 хүн буюу 52.1 хувь нь эмэгтэй, 583 хүн буюу 47.9 хувь нь эрэгтэй байна.

Насны бүтцээр авч үзэхэд судалгаанд оролцогчдын 60.6 хувь нь 25-44 насны хүн эзэлж байгаа бол 5.2 буюу хувийг буюу 185 хүн нь 24 нас хүртэлх иргэд байна.


График 22. Судалгаанд оролцогчид насны бүтцээр



Нийт судалгаанд хамрагдсан 1218 хүнийг боловсролын түвшингөөр авч үзэхэд бүрэн дунд боловсролтой иргэн 531 буюу 43.8 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн 13.8 хувь, бакалаврын дээд боловсролтой иргэд 17,4 хувь буюу 211 хүн хамрагджээ.


График 23. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

⁶ Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.




Ажилгүй иргэдээс ямар хугацаанд ажил эрхлэхгүй байгааг нь тодруулахад 14 хувь нь 1-6 сар, 11.4 хувь нь 7-12 сар, 10.3 хувь нь 13-24 сарын хугацаанд ажил эрхлээгүй гэж хариулсан бол 2 жилээс дээш хугацаанд ажилгүй байгаа гэж судалгаанд оролцсон иргэдийн 58.7 хувь нь буюу 715 хүн хариулсан байна.

График 24. Ажил эрхлээгүй байсан хугацаа



Судалгаанд оролцсон иргэдийн хөдөлмөр эрхлээгүй байгаа шалтгааныг тодруулахад 31.4 хувь нь эзэмшсэн мэргэжилгүйн улмаас, 19.1 хувь нь амьдарч буй газар ажлын байр хомс, 17 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 12.2 хувь нь насны ялгаварлалтаас гэж хариулсан байна.

График 25. Ажил эрхлэхгүй байгаа шалтгаан



Судалгаагаар “Та аль салбарт ажиллах сонирхолтой байна?” гэсэн асуултад нийт судалгаанд оролцогчдын 33.6 хувь нь төрийн байгууллагад ажиллах сонирхолтой, 43.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой, 19 хувь нь хувийн хэвшилд ажилд орох хүсэлтэй байгаа бол 4.4 хувь нь хувиараа компани үүсгэн байгуулж ажиллах сонирхолтой байна.

Үүнийг боловсролын түвшингөөр харьцуулж үзэхэд бакалаврын дээд боловсролтой иргэдийн дийлэнх олонх нь төрийн байгууллагад ажиллах хүсэлтэй бол бүрэн дунд, суурь/бүрэн бус дунд/, бага боловсролтой иргэд хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой байна.

Хүснэгт 40. Ажил эрхлэхгүй байгаа иргэд боловсролын түвшин, ажиллах сонирхолтой салбараар

№	Боловсролын түвшин	Ажиллах сонирхолтой салбар				
		Төрийн байгууллагад	Хувийн хэвшилд	Хувиараа хөдөлмөр эрхлэх	Аж ахуй нэгж байгуулан ажиллах	Нийт
1	Боловсролгүй	5	8	22	5	40
2	Бага	18	35	70	2	125
3	Суурь /бүрэн бус дунд/	20	28	51	2	101
4	Бүрэн дунд	139	104	229	20	492
5	Техникийн, буюу тусгай дунд	20	11	27	2	60
6	Мэргэжлийн боловсрол /МСҮТ/	40	10	42	5	97
7	Бакалавр	132	17	41	12	202
8	Магистр	4	0	1	0	5
Нийт		378	213	483	48	1122

Судалгаанд оролцогчдын ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг насны бүлгээр авч үзэхэд 24 хүртэлх насныхан мэргэжилгүйн улмаас ажилд орж чадахгүй байна гэсэн хариулт өгсөн бол 25-34 насны иргэд тухайн газар ажлын байр хомс, мэргэжилд тохирох ажил олдохгүй байна гэж 50 гаруй хувь нь хариулсан байна. 35-44 насныхан мэргэжилгүй тул ажил олдохгүй байна гэж дийлэнх нь хариулсан бол 45 дээш насныхан насны ялгаварлалтын улмаас ажилд орж чадахгүй байна гэсэн хариултыг өгчээ.


Хүснэгт 41. Ажилд эрхлэхгүй байгаа шалтгаан насны бүлгээр

№	Ажил эрхлэхгүй байгаа шалтгаан	Насны бүлгээр					НИЙТ
		24 хүртэл нас	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55 дээш нас	
1	Цомхотголд орсон	2	8	12	9	3	34
2	Байгууллага татан буугдсан	1	4	2	8	2	17
3	Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа	36	112	33	15	5	201
4	Мэргэжил ур чадвараар тэнцэхгүй байгаа	4	13	12	4	0	33
5	Ажил олгогчдийн тавьсан шаардлагад нийцэхгүй	10	13	13	4	4	44
6	Мэргэжилгүйгээс	64	118	121	53	15	371
7	Насны ялгаварлалаас	1	1	35	74	33	144
8	Эрүүл мэндийн байдлаас	2	19	11	13	2	47
9	Ар гэрийн шалтгаантай	1	13	8	5	1	28
10	Цалин бага	2	6	4	2	1	15
11	Мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй	5	5	8	2	1	21
12	Амьдарч буй газар ажлын байр хомс	52	96	50	21	6	225
НИЙТ		180	408	309	210	73	1180

Танд хөдөлмөр эрхлэхэд ямар мэдлэг, ур чадвар хандлага дутаж байна гэсэн асуултад судалгаанд оролцогчид мэргэжлийн суурь мэдлэг, ур чадвар, компьютерийн мэдлэг, бизнес эрхлэх

мэдлэг хамгийн их дутагдаж байна гэсэн бол харилцааны соёл, шинийг санаачлах, удирдлагын мэдлэг ур чадвар, багаар ажиллах ур чадварууд хамгийн бага хувийг эзэлж байна.

График 26. Танд хөдөлмөр эрхлэхэд ямар мэдлэг, ур чадвар хандлага дутаж байна?



ХОЁР: ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Ажил олгогчийн ерөнхий мэдээлэл

Бизнес регистрийн⁷ санд бүртгэлтэй Хөвсгөл аймгийн аж ахуй нэгжийн тоог 2021 оны 3-р улирлаар авч үзэхэд бүртгэлтэй аж ахуй нэгжийн тоо 2582 байна. Үүнээс үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тоо 1637, үйл ажиллагаа эрхлээгүй 329, түр зогсоосон 434, бүрэн зогсоосон 175 аж ахуй нэгж байна. Бүртгэлтэй аж ахуй нэгжүүдийг сумдаар авч үзэхэд Мөрөн суманд бүртгэлтэй 1325 аж ахуй нэгжийн 875 үйл ажиллагаа явуулж байгаа бол хүн ам олонтой сумд болох аялал жуулчлал түлхүү хөгжсөн Алаг-Эрдэнэ суманд 69 аж ахуй нэгж, газар тариалан түлхүү хөгжсөн Тариалан суманд 67 аж ахуй нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 42. Бүртгэлтэй аж ахуйн нэгж сумдаар

№	Сумдаар	НИЙТ	Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа эрхлээгүй	Үйл ажиллагаа түр зогсоосон	Үйл ажиллагаа бүрэн зогсоосон	Олдохгүй байгаа болон бусад
	Бүгд	2 582	1 637	329	434	175	7
1	Алаг-Эрдэнэ	122	69	12	18	21	2
2	Арбулаг	24	18	4	1	1	0
3	Баянзүрх	39	24	3	7	5	0
4	Бүрэнтогтох	65	52	4	6	3	0
5	Галт	69	41	4	10	14	0
6	Жаргалант	68	38	3	22	5	0
7	Их-Уул	63	43	3	5	12	0
8	Рашаант	48	36	4	7	1	0
9	Рэнчинлхүмбэ	40	19	2	16	3	0
10	Тариалан	98	67	4	17	10	0
11	Тосонцэнгэл	69	33	2	27	7	0
12	Төмөрбулаг	46	30	4	8	3	1
13	Түнэл	51	26	10	10	5	0
14	Улаан-Уул	51	40	2	4	5	0
15	Ханх	53	23	8	15	7	0
16	Цагаан-Уул	54	27	8	18	1	0
17	Цагаан-Үүр	42	21	6	9	5	1
18	Цэцэрлэг	79	50	8	19	2	0
19	Чандмань-Өндөр	42	29	2	11	0	0
20	Шинэ-Идэр	44	26	6	7	5	0
21	Мөрөн	1 325	875	228	172	47	3
22	Эрдэнэбулган	50	33	1	4	12	0
23	Цагааннуур	40	17	1	21	1	0

⁷ Бизнес регистрийн санд гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг агуулсан мэдээллийн сан

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст хандан татвар төлдөг 1878 аж ахуй нэгж нийгмийн даатгал төлдөг 803 аж ахуйн нэгжийн судалгааг гаргуулан авсан.

Аймгийн Татварын хэлтсийн 1878 харилцагч байгууллагуудын мэдээлэлд байгаа хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийн нийт ажиллагсад нь 5307 байгаа нийгмийн даатгалын 803 байгууллага нийт 5010 ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөн үйл ажиллагаа явуулж байна.

Бизнес регистрийн санд буй үйл ажиллагаа явуулж буй байгууллага, болон аймгийн Татвар, Нийгмийн даатгалын хэлтсүүдээс авсан аж ахуй нэгжийн тоог дунджаар авч үзэхэд Хөвсгөл аймгийн хэмжээнд 1500 орчим хувийн хэвшлийн аж ахуй нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж 5000 гаруй иргэдийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Татварын мэдээллийн санд буй аж ахуй нэгжийн тоог сумдаар нь ангилж ажилтны тоог нь авч үзэхэд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж буй 825 аж ахуй нэгжид 3427 хүн ажиллаж байгаа бол байршил хаяг тодорхойлогдохгүй 151 аж ахуй нэгжид 240 хүн ажиллаж байна. Газар тариалангийн гол бүс нутаг болох Тариалан суманд үйл ажиллагаа явуулж 81 аж ахуй нэгж нийт 273 хүнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.

Хүснэгт 43. Татварын мэдээлэлд буй аж ахуй нэгж байгууллага сумдаар


№	Сум	ААН-ын тоо	Ажилчдын тоо
1	Алаг-Эрдэнэ	71	85
2	Арбулаг	15	21
3	Баянзүрх	26	23
4	Бүрэнтогтох	40	65
5	Галт	51	51
6	Жаргалант	71	105
7	Их-уул	46	103
8	Рашаант	36	67
9	Рэнчинлхүмбэ	30	72
10	Тариалан	81	273
11	Тосонцэнгэл	44	72
12	Төмөрбулаг	31	45
13	Түнэл	38	69
14	Улаан-Уул	44	110
15	Ханх	45	48
17	Цагааннуур	34	41
18	Цагаан-Уул	40	81
19	Цагаан-Үүр	28	27
20	Цэцэрлэг	41	155
21	Чандмань-Өндөр	36	37
22	Шинэ-Идэр	17	48
23	Эрдэнэбулган	36	42
24	Мөрөн	825	3427
25	Байршил тодорхойгүй	151	240
	Нийт	1877	5307

2.2 Ажил олгогчийн дунд хийсэн судалгааны үр дүн

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн аж ахуй нэгж, ажил олгогчдоос санал асуулгын судалгаа зохион байгууллаа. Энэхүү судалгаанд нийт 101 аж ахуй нэгж хамрагдсан бөгөөд 5 хүртэл жил үйл ажиллагаа


явуулсан 19, 6-10 жил үйл ажиллагаа явуулсан 35, 11-15 жил үйл ажиллагаа явуулсан 24, 16 дээш жил үйл ажиллагаа явуулсан 23 байгууллага судалгаанд хамрагдсан байна.

График 27. Үйл ажиллагаа явуулсан жил хувиар




Судалгаанд хамрагдсан байгууллага, ажил олгогчид шинээр ажилтан авахдаа ямар шаардлага тавьдаг эсэхийг судлан үзэхэд ажил олгогч нар хувийн зохион байгуулалт, (хорт зуршил) ажлын ачаалал даах чадвар, харилцааны соёл, мэргэжлийн мэдлэг ажлын туршлагыг илүүтэй голчлон үздэг байна.

График 28. Шинээр ажилтан авахдаа ямар шаардлага тавьдаг эсэх




Мөн тухайн байгууллагаас хүн ажлаас гарч байгаа тохиолдолд ямар учир шалтгаан нөлөөлж байгааг асуухад ажиллаж байсан ажлын байр нь түр ажлын байр байсан, ажилтан өөр ажилд шилжсэн, ажлын хариулцлага алдсан, өөр тийш шилжин суурьшихаар болсон, харилцаа хандлага тохироогүй гэсэн шалтгаанууд голлон нөлөөлж байна.

График 29. Ажлаас гарч буй шалтгаан нөлөөлөл



Судалгаанд оролцсон ажил олгогч нараас шинээр ажилтан авахдаа мэдээллийн ямар эх үүсвэр ашигладаг вэ? гэсэн асуултад хүмүүс өөрсдөө ханддаг гэж 52 хүн буюу 51.5 хувь нь хариулсан бол цахим сүлжээнд зар оруулан ажилд авдаг гэж 35 хүн буюу 34.7 хувь нь хариулсан байна.

График 30. Шинээр ажилтан авахдаа ашигладаг мэдээллийн эх үүсвэр




2.3 Ажлын зард хийсэн дүн шинжилгээ

Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж гүйцэтгэх явцад цахим орчинд орсон ажлын зард дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ 2021 оны 9-11 сарын хугацаанд аймгийн хамгийн том зарын фэйсбүүк групп болох “Хөвсгөлийн нэгдсэн зар мэдээ”, “Бүх хөвсгөлчүүд энд” мөн Хөвсгөл аймгийн ХХҮГ-ын пэйж хуудсаар зарлагдсан ажлын байрны зард дүн шинжилгээ хийсэн.

2021 оны 9-11 сарын хугацаанд буюу нийт 3 сарын хугацаанд зөвхөн дээр дурдсан мэдээллийн сувгаар давхацсан тоогоор 350 зар тавигдаж 500 орчим ажлын байр зарлагджээ.


Зарлагдсан ажлын байрыг түр болон байнгын улирлын болон цагийн ажлын байраар нь шүүн ангилж үзэхэд нийт зарлагдсан ажлын байрны 71.3 хувь нь байнгын ажлын байр, 15.4 хувь нь улирлын шинж чанартай ажлын байр, 7.7 хувь нь түр ажлын санал, 5.6 хувь нь цагийн ажлын зар эзэлж байна.

График 31. Зарлагдсан ажлын байр




Ажлын байрны агуулгад дүн шинжилгээ хийж нарийн мэргэжил шаардлагатай эсэх талаар нь ангилж үзэхэд нийт зарлагдсан ажлын байрны 77.6 хувь нь заавал нарийн мэргэжлийн боловсрол шаардлагагүй ажил байсан бөгөөд 14.7 хувь нь тусгай дунд мэргэжил шаардлагатай 4.7 хувь нь дээд мэргэжил шаардлагатай ажлын байр байв.

График 32. Зарлагдсан ажлын байранд нарийн мэргэжил шаардлагатай эсэх



Зарлагдсан ажлын байрыг салбараар авч үзэхэд нийт зарын хамгийн их хувь буюу 35.4 хувь нь үйлчилгээний байгууллага, 15.8 хувь нь худалдааны салбар байсан бол 8.8 хувь нь барилга 4.7 хувь нь харуул хамгаалалттай холбоотой ажлын байрны зарууд эзэлж байна.

График 33. Зарлагдсан ажлын байрыг салбараар




Судалгааны мэдээллийн чанарыг сайжруулах ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг дэлгэрүүлэн судлах зорилгоор ажлын зар байршуулсан 122 ААН байгууллага, хувь хүнээс телефон асуулгын арга болон “google forms” ашиглан санал асуулгын судалгааг зохион байгууллаа. Судалгаанд Номин, Дөл түр, Хөвсгөл Центр, Танил, Жаргалан, Хөвсгөл Титаник, Алтандуулга,

Бүтэн-Оргил, Хөвсгөл тэвхэн, Шинэ мөрөн ХҮТ, Лидер махны үйлдвэр зэрэг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон ажил олгогчид болон жижиг хүнсний цех дэлгүүр хувь хүмүүс хамрагдсан.

Судалгаанд тухайн байгууллага хэдэн хүнийг ажлын байраар ханган ажилладаг вэ? гэсэн асуултад нийт 109 байгууллага хариулсан бөгөөд энэхүү 109 байгууллага нийт 1360 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байгаа юм.


Та цахим орчинд ямар төрлийн ажлын зар оруулсан бэ? гэсэн асуултад нийт судалгаанд оролцсон 122 ажил олгогчийн 75.4 хувь нь байнгын ажлын зар, 8.2 хувь түр ажлын байр, 16.4 хувь нь улирлын чанартай ажлын зар оруулсан гэж хариулжээ.

График 34. Ажлын зарын төрөл




Та цахим орчинд оруулсан зарынхаа дагуу хүссэн ажилтнаа ажилд авч чадсан уу? гэсэн асуултад судалгаанд оролцсон ажил олгогчдын 68.9 хувь нь зараар дамжуулан ажилд авсан хэмээн хариулсан бол 13.1 хувь нь одоо хүртэл хүссэн ажилтнаа олж авч гэжээ. Мөн судалгаанд оролцсон ажил олгогчдын 50 хувь нь буюу 61 ажил олгогч зарын дагуу 6 ба түүнээс дээш хүн холбогдсон гэсэн бол 4-6 хүн холбогдсон гэсэн хариулт 33.6 хувь, 3 хүртэл хүн холбогдсон гэдэг нь 13.9 хувь байсан бөгөөд нэг ч хүн холбогдоогүй гэж 3 хүн буюу 2.5 хувь нь хариулсан байна

График 35. Зарын дагуу ажилтан олж авсан эсэх




Өмчлөлийн хувьд ямар байгууллагад ажил авахаар зар оруулсан бэ? гэсэн асуултад 77.9 хувь нь хувийн хэвшлийн аж ахуй нэгж байсан бол 10.7 хувь нь хувийн цех дэлгүүр, цайны газар байв.

График 36. Зар оруулсан байгууллага өмчлөлийн хэлбэрээр




Ажил олгогчдоос зарласан ажлын байрандаа ажилтан авч ажиллуулахдаа дараах шалгуураас алийг нь илүү анхаарч үздэг вэ? гэсэн асуултад тууштай байдал, харилцаа хандлага, туршлага ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг үзүүлэлтийг илүүтэй анхаардаг хэмээжээ.

График 37. Ажлын байранд ажилтан шинээр авахад анхаарч үздэг шалгуурууд



Зар оруулсан ажил олгогчдоос та Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэнд ажлын байрны захиалгаа өгч байсан уу гэсэн асуултад 41 хувь нь захиалгаа өгч байгаагүй, 44.3 хувь нь захиалгаа өгч байсан гэж хариулсан бол 14.8 хувь нь тийм үйлчилгээ байдгийг мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.


График 38. Ажил олгогч ХХҮГ-аар дамжуулан ажлын байрны захиалгаа өгдөг эсэх



Зарын дагуу ажилд авсан ажил нь тухайн зарласан ажлын байрны шаардлагад хэр нийцэж байна вэ? гэсэн асуултад ажил олгогчид 64.8 хувь нь буюу 79 хүн нийцэж байна гэсэн хариултыг өгч 35.2 хувь нь ажилд авсан хүн тухайн ажлын байранд нийцэхгүй байна гэсэн хариултыг өгчээ. Мөн танд одоо шинээр ажилтан авах хэрэгцээ шаардлагатй ажлын байр байна уу? гэсэн асуултад 68.9 хувь нь буюу 84 ажил олгогч “тийм” гэж хариулсан бөгөөд нийт 224 шинэ ажлын байранд хүн авах хэрэгцээ шаардлага байна.

Судалгаанд оролцсон ажил олгогчдоос “Та хүмүүс ажил эрхлэх сонирхолгүй байна гэсэн хандлага ойлголттой санал нийлэх үү” гэсэн асуултад 91 хувь нь “Санал нийлнэ” гэсэн хариултыг өгчээ. Хэрвээ санал нийлж байвал ямар шалтгаантай холбон тайлбарлах вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулт өгчээ.

График 39. Ажиллах хүчний хомсдолын шалтгаан



2.4 Төрийн албан хаагчдын тоон мэдээлэл

2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн насны хүн амыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзэхэд аймгийн хэмжээнд байнгын ажиллагч 18049 хүн байна. Үүний 40 хувь нь буюу 7171 хүн нь төрийн албанд ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчдыг сумдаар болон хүйс, албан тушаалын төрлөөр ангилж үзэхэд 4852 эрэгтэй албан хаагч, 2319 эмэгтэй албан хаагч байна. Нийт 7171 албан хаагчийн 42.3 хувь буюу 3038 албан хаагч Мөрөн суманд ажиллаж байна.

Бусад сумдаас засаг захиргааны онцлогоос шалтгаалж Алаг-Эрдэнэ сумын Захирагчийн албанд хамгийн олон албан хаагч буюу нийт 283 хүн байгаа бол хүн ам олонтой Галт, Тариалан, Жаргалант, Цагаан-Уул 200-аас дээш тооны төрийн албан хаагч ажиллаж байна.

Хүснэгт 44. Төрийн албан хаагчийн тоо сумд, хүйс, албан тушаалын төрлөөр.

№	Сум	Нийт	Хүйс		Албан тушаалын төрөл		
			Эмэгтэй	Эрэгтэй	Удирдах	Гүйцэтгэх	Туслах
1	Мөрөн	3038	2037	1001	144	2359	535
2	Алаг-Эрдэнэ	283	185	98	23	155	105
3	Арбулаг	179	113	66	21	119	39
4	Баянзүрх	183	112	71	10	117	56
5	Бүрэнтогтох	177	118	59	15	104	58
6	Галт	236	172	64	20	156	60
7	Жаргалант	208	142	66	18	171	19

8	Их-Уул	177	127	50	19	122	36
9	Рашаант	162	121	41	15	130	17
10	Рэнчинлхүмбэ	187	134	53	17	109	61
11	Тариалан	225	161	64	17	171	37
12	Тосонцэнгэл	175	132	43	18	124	33
13	Төмөрбулаг	148	99	49	13	102	33
14	Түнэл	169	112	57	15	119	35
15	Улаан-Уул	214	141	73	17	128	69
16	Ханх	186	122	64	19	136	31
17	Цагааннуур	138	96	42	15	76	47
18	Цагаан-Уул	227	161	66	18	144	65
19	Цагаан-Үүр	152	98	54	15	97	40
20	Цэцэрлэг	199	141	58	18	130	51
21	Чандмань-Өндөр	174	110	64	16	117	41
22	Шинэ-Идэр	161	104	57	13	104	44
23	Эрдэнэбулган	173	114	59	13	120	40
Нийт		7171	4852	2319	509	5110	1552

Нийт төрийн албан хаагчийг насны ангиллаар нь авч үзэхэд 21 хүртэлх насны төрийн албан хаагч аймгийн хэмжээнд 6 хүн байгаа бол 60 дээш насны төрийн албан хаагч 52 хүн байна. 50 дээш насны төрийн албан хаагч аймгийн хэмжээнд нийт 1287 хүн байгаа бөгөөд жилд дунджаар 400 шинэ ажлын байр бий болох тооцоолол байна.

Хүснэгт 45. Төрийн албан хаагчид насны ангиллаар

№	Сум	Нийт	Насны ангилал									
			21 хүртэлх насны	21-25 насны	26-30 насны	31-35 насны	36-40 насны	41-45 насны	46-50 насны	51-55 насны	56-60 насны	60-аас дээш насны
1	Мөрөн	3038	3	145	422	614	439	431	429	385	150	20
2	Алаг-Эрдэнэ	283	0	12	40	56	48	32	47	30	17	1
3	Арбулаг	179	0	8	37	35	27	15	26	23	5	3
4	Баянзүрх	183	0	11	35	35	27	9	24	29	10	3
5	Бүрэнтогтох	177	1	16	31	43	18	16	23	20	8	1
6	Галт	236	0	12	42	40	35	37	34	31	4	1
7	Жаргалант	208	1	8	34	42	33	14	25	34	15	2
8	Их-Уул	177	0	13	23	28	24	27	39	17	6	0
9	Рашаант	162	0	6	14	36	26	23	28	24	4	1
10	Рэнчинлхүмбэ	187	1	8	21	40	22	22	26	35	11	1
11	Тариалан	225	0	11	32	35	30	35	26	38	14	4
12	Тосонцэнгэл	175	0	9	26	40	25	18	30	22	5	0
13	Төмөрбулаг	148	0	5	22	34	17	13	26	20	9	2
14	Түнэл	169	0	8	31	25	28	19	29	19	9	1
15	Улаан-Уул	214	0	6	41	54	20	30	22	29	11	1
16	Ханх	186	0	17	15	44	30	26	22	20	8	4
17	Цагааннуур	138	0	5	17	38	18	13	17	19	10	1
18	Цагаан-Уул	227	0	22	33	49	37	20	25	28	12	1
19	Цагаан-Үүр	152	0	4	17	31	28	18	26	18	8	2
20	Цэцэрлэг	199	0	8	31	39	33	28	28	27	5	0
21	Чандмань-Өндөр	174	0	9	22	33	24	17	23	29	15	2

22	Шинэ-Идэр	161	0	9	21	34	21	22	23	24	7	0
23	Эрдэнэбулган	173	0	8	19	49	32	17	24	18	5	1
Нийт		7171	6	360	1026	1474	1042	902	1022	939	348	52


Хөвсгөл аймагт 2019-2021 онд нийт 4 удаа төрийн албаны нөөцөд бүртгэх ерөнхий шалгалт зохион байгуулагдсан бөгөөд энэхүү шалгалтад давтагдсан тоогоор нийт 2102 иргэн бүртгүүлэн шалгалт өгч 479 иргэн тэнцэн төрийн албаны нөөцөд орсон байна.

2.5 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд хийсэн судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2021 оны аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн улсын тооллогоор нийт 1677 хувиараа хөдөлмөр эрхлэгч тоолуулсан байна. Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд аймгийн Татварын хэлтсээс хувь хүний орлогын албан татвар төлдөг 1408 хувиараа хөдөлмөр эрхлэгчийн судалгааг гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ.

Хувиараа хөдөлмөр эрхэлж хүн амын татвар төлж буй иргэдийг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь ангилж үзэхэд 554 хүн буюу 39,3 нь хүнс барааны дэлгүүр лангуу ажиллуулж байгаа бол 27,9 хувь нь бараа бэлэн хувцас зарж байна. Энэ хоёр ангилал нийлээд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 67,2 хувийг эзлэж байна. Үүний дараа үсчин гоо сайхны үйлчилгээ үзүүлж буй иргэд, ахуйн бараа зарж борлуулж буй иргэд орж байна.

График 40. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид үйл ажиллагааны салбараар



Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг сумдаар болон нас хүйсээр авч үзэхэд Мөрөн суманд 1085 хүн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нь нийт хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 77.5 хувийг эзлэж байна. Нийт 1408 иргэнийг насны ангиллаар авч үзэхэд 65 хувь нь буюу 925 эмэгтэй хүн байна. Насны бүтцээр авч үзэхэд 30 хүртэл насны 93 иргэн байгаа бол 51-50 насны

Хүснэгт 46. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид сумдаар болон нас хүйсээр


№	Сум	БҮГД	Хүйс		Нас				
			Эм	Эр	30 хүртэл	31-40	41-50	51-60	60 дээш

1	Алаг-Эрдэнэ	7	1	6	1	0	4	2	0
2	Арбулаг	4	2	2	0	0	2	2	0
3	Баянзүрх	25	14	11	0	5	13	4	3
4	Бүрэнтогтох	15	11	4	1	5	2	5	2
5	Галт сум	18	8	10	2	2	10	3	1
6	Жаргалант	26	14	12	0	7	9	5	5
7	Их-Уул	12	1	11	1	3	4	3	1
8	Мөрөн	1085	756	329	75	287	391	237	95
9	Рашаант	2	0	2	0	1	1	0	0
10	Рэнчинлхүмбэ	13	9	4	1	2	3	3	4
11	Тариалан	17	9	8	2	3	7	4	1
12	Тосонцэнгэл	11	7	4	0	0	5	5	1
13	Төмөрбулаг	12	1	11	0	0	3	7	2
14	Түнэл	16	11	5	1	5	2	6	2
15	Улаан-Уул	10	2	8	0	1	2	7	0
16	Ханх	19	14	5	1	4	10	3	1
17	Хатгал	14	12	2	0	0	8	6	0
18	Цагаан-Уул	23	9	14	0	6	9	8	0
19	Цагаан-Үүр	13	8	5	1	2	1	7	2
20	Цагааннуур	11	7	4	2	1	0	5	3
21	Цэцэрлэг	17	11	6	1	3	6	5	2
22	Чандмань-Өндөр	13	5	8	1	8	0	4	0
23	Шинэ-Идэр	12	5	7	1	1	5	5	0
24	Эрдэнэбулган	13	8	5	2	2	3	4	2
НИЙТ		1408	925	483	93	348	500	340	127

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны хүрээнд нийт 807 хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс санал асуулгын судалгаа авлаа. Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 263 хүн буюу 32.6 хувь нь 45-54 насныхан, 236 хүн буюу 26.2 хувь нь 35, 44 насныхан байгаа бол 24 нас хүртэл хувиараа хөдөлмөр эрхлэгч 23 хүн буюу 2.9 хувийг эзлэж байна. Нийт судалгаанд оролцогчдийн 55,4 хувь нь буюу 447 хүн эмэгтэй байгаа бол 3 жил хүртэл хувиараа хөдөлмөр эрхэлсэн иргэд 216 буюу 26.8 хувь, 4-7 жил хувиараа хөдөлмөр эрхэлсэн иргэд 163 буюу 20.2 хувь 8-11 жил хувиараа хөдөлмөр эрхэлсэн иргэд 161 буюу 20 хувь, 12 жилээс дээш хувиараа хөдөлмөр эрхэлсэн иргэд 31.7 хувийг эзлэж байна.


Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс тулгамдаж байгаа асуудлыг тодруулахад Мөнгө санхүүгийн бэрхшээл 66 хувь гэж хариулсан бол 14.7 хувь нь зах зээл жижиг байна. 10.8 хувь нь ажиллах хүч дутмаг байна хэмээн хариулжээ.

График 41. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал




Судалгаанд оролцогчдоос та өөрийн эрхэлж буй бизнесээ өргөжүүлж аж ахуй нэгж болох сонирхол байгаа юу гэсэн асуултад 54 хувь нь тийм гэж хариулсан бол 24.4 хувь нь тийм бодол байхгүй, 16.7 хувь нь энэ талаар бодож байгаагүй гэсэн хариултыг өгчээ.

График 42. Та өөрийн эрхэлж буй бизнесээ өргөжүүлж, аж ахуй нэгж болох сонирхол байгаа юу?



Өөрийн эрхэлж буй үйл ажиллагаагаа цааш нь өргөтгөж аж ахуй нэгж байгууллага болох хүсэлтэй 440 хувиараа хөдөлмөр эрхлэгчээс цаашид ямар хэлбэрээр үйл ажиллагаагаа өргөжүүлж аж ахуй нэгж байгуулахыг хүсэж байгаа талаар тодруулахад 48.5 хувь нь компани, 26.6 хувь нь Хоршоо, 24.8 хувь нь нөхөрлөл, байгуулах хүсэл сонирхолтой байна.


График 43. Цаашид ямар аж ахуй нэгж байгуулах сонирхолтой вэ?



Хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс хэрвээ ажилтан авах хэрэгцээ шаардлага байдаг бол хүний нөөцтэй холбоотой ямар асуудал тулгардаг болохыг судалгаагаар тодруулж асуухад нийт судалгаанд оролцсон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 609 нь буюу 75.5 хувь нь энэхүү асуултад

хариулсан байна. Үүний 36.3 хувь нь цалин голдог, 35.3 хувь нь мэргэжлийн ур чадвар муу, идэвх санаачилга сул хэмээн хариулсан байна.

График 44. Ажилтан авахад тулгамдаж буй асуудал



2.2 Малчдын дунд хийсэн судалгааны үр дүн

Хөвсгөл аймгийн нийт ажиллах хүчний 50 гаруй хувийг дангаараа эзэлж буй эдийн засгийн салбар бол Хөдөө аж ахуйн салбар юм. Энэ салбар нь зөвхөн ажиллах хүчний хувьд гэлтгүй эдийн засгийн хувьд ч аймгийн хамгийн том салбар юм. Хөвсгөл аймаг нь 2018 онд 5 сая 710 мянган мал, 2019 онд 6 сая гаруй мал, 2020 онд 5 сая 500 мянган мал тоолуулж улсад малын тоогоор тогтмол 1-2 байранд эзлэж байна.

Хөвсгөл аймгийн малчин өрхийг сүүлийн 5 жилээр авч харьцуулан үзэхэд өрхийн тоо 2020 онд 2246 өрхөөр өссөн байна. Үүнд Мөрөн сум 250 өрхөөр, Жаргалант сум 231 өрхөөр Алаг-Эрдэнэ сум 212 өрхөөр, Тосонцэнгэл сум 196 өрхөөр, Арбулаг сум 191 өрхөөр өссөн байна.

Өрхийн тоо хамгийн тогтмол байгаа сум нь Цэцэрлэг сум бөгөөд Шинэ-Идэр сум 16 өрхөөр, Цагаан-Үүр сум 42, Эрдэнэбулган сум 46 өрхөөр тус тус нэмэгджээ.

Хүснэгт 47. Малчин өрхийн тоо сүүлийн 5 жилээр сумдаар

№	Сумын нэр	Малчин өрхийн тоо					Өрхийн өсөлт 2016-2020
		2016	2017	2018	2019	2020	
	Бүгд	15267	16657	16763	16913	18113	2846
2	Мөрөн	574	719	683	687	824	250
3	Алаг-Эрдэнэ	786	848	910	917	998	212
4	Арбулаг	715	785	837	859	906	191
5	Баянзүрх	634	681	611	662	716	82
6	Бүрэнтогтох	849	913	974	949	1023	174
7	Галт	1009	1106	1062	1119	1140	131
8	Жаргалант	866	989	1055	994	1097	231
9	Их-Уул	678	728	719	760	809	131
10	Рашаант	579	585	637	615	645	66
11	Рэнчинлхүмбэ	870	963	963	957	982	112
12	Тариалан	747	814	804	826	888	141
13	Тосонцэнгэл	674	750	800	795	870	196

14	Төмөрбулаг	712	784	781	787	869	157
15	Түнэл	682	776	749	770	865	183
16	Улаан-Уул	677	704	699	721	750	73
17	Ханх	348	371	362	391	428	80
18	Цагааннуур	145	206	215	268	252	107
19	Цагаан-Уул	1068	1145	1182	1173	1232	164
20	Цагаан-Үүр	315	349	343	342	357	42
21	Цэцэрлэг	861	873	842	812	861	0
22	Чандмань-Өндөр	471	519	492	491	532	61
23	Шинэ-Идэр	554	591	590	549	570	16
24	Эрдэнэбулган	453	458	453	469	499	46

Малчдын тоог сүүлийн 5 жилээр авч үзэхэд 2018, 2019 онд буурах хандлагатай байсан бол 2020 онд буцаад өссөн байна. Үүнийг сумдаар авч үзэхэд малчны өрхийн тоо хэдий өссөн ч малчдын тоо харьцангуй тогтмол байна. 2016 оны оноос хойш малчдын тоо ердөө 135 малчнаар өссөн бөгөөд малчин өрхийн өсөлт бага байсан сумд болох Шинэ-Идэр, Цагаан-Үүр, Цэцэрлэг сумдад малчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 48. Малчдын тоо сүүлийн 5 жилээр сумдаар

№	Сумд	Малчдын тоо оноор					Малчны өсөлт
		2016	2017	2018	2019	2020	2016-2020
	Бүгд	31155	31239	29589	29394	31290	135
1	Мөрөн	1115	1129	944	898	1249	134
2	Алаг-Эрдэнэ	1587	1742	1638	1629	1776	189
3	Арбулаг	1366	1332	1452	1546	1512	146
4	Баянзүрх	1366	1278	1156	1266	1391	25
5	Бүрэнтогтох	1727	1666	1686	1580	1707	-20
6	Галт	2019	2102	1926	1997	1919	-100
7	Жаргалант	1768	1701	1581	1597	1665	-103
8	Их-Уул	1326	1282	1204	1316	1412	86
9	Рашаант	1154	1106	1209	1156	1167	13
10	Рэнчинлхүмбэ	1882	1968	1722	1758	1824	-58
11	Тариалан	1470	1520	1360	1307	1404	-66
12	Тосонцэнгэл	1366	1345	1445	1364	1473	107
13	Төмөрбулаг	1461	1427	1309	1388	1586	125
14	Түнэл	1359	1368	1232	1238	1418	59
15	Улаан-Уул	1537	1421	1443	1357	1293	-244
16	Ханх	764	754	781	679	704	-60
17	Цагааннуур	326	403	389	434	423	97
18	Цагаан-Уул	2139	2257	2270	2210	2369	230
19	Цагаан-Үүр	646	815	656	574	627	-19

20	Цэцэрлэг	1775	1702	1499	1384	1416	-359
21	Чандмань-Өндөр	982	1047	956	962	1013	31
22	Шинэ-Идэр	1125	1043	926	872	993	-132
23	Эрдэнэбулган	895	831	805	882	949	54

Малтай өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзэхэд 200 хүртэл малтай өрх 11994, 201-500 хүртэл малтай өрх 6206, 501-9999 хүртэл малтай өрх 2562 байгаа бол 1000 дээш малтай өрх 622 байна. Үүнийг сумдаар нь үзэхэд 500 дээш толгой малтай өрхийн тоогоор Цагаан-Уул, Арбулаг, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Төмөрбулаг сумд тэргүүлж байна.

Хүснэгт 49. Малтай өрхийг малын тоогоор

№	Сумын нэр	200 хүртэл	201-500 хүртэл	501-999 хүртэл	1000 дээш
	Бүгд	11994	6206	2562	622
1	Мөрөн	619	327	90	17
2	Алаг-Эрдэнэ	787	331	110	39
3	Арбулаг	342	377	206	82
4	Баянзүрх	377	349	173	41
5	Бүрэнтогтох	432	419	207	63
6	Галт	703	405	158	22
7	Жаргалант	798	341	75	9
8	Их уул	388	277	143	43
9	Рашаант	407	245	118	16
10	Рэнчинлхүмбэ	824	278	70	16
11	Тариалан	607	263	92	20
12	Тосонцэнгэл	388	294	196	43
13	Төмөрбулаг	356	372	187	48
14	Түнэл	435	359	131	36
15	Улаан-Уул	611	257	81	17
16	Ханх	453	64	14	0
17	Цагаан нуур	383	17	2	0
18	Цагаан-Уул	603	442	237	75
19	Цагаан-үүр	507	18		0
20	Цэцэрлэг	581	371	128	15
21	Чандмань-Өндөр	536	75	16	3
22	Шинэ Идэр	439	213	85	11
23	Эрдэнэбулган	418	112	43	6


Хөдөлмөрийн зах зээлийн хүрээнд аймгийн 23 сум 1 тосгоноос нийт 1037 малчныг түүвэрлэн санал асуулгын судалгааг зохион байгууллаа.

Судалгаанд 24 хүртэл насны 37 малчин, 25-34 хүртэлх насны 353 малчин, 35-44 хүртэлх насны 344 малчин, 45-54 насны 240 малчин, 55 дээш насны 63 малчин хамрагдсан байна 25-44 насны малчид нийт судалгаанд хамрагдсан малчдын 67.2 хувийг эзлэж байна.

Судалгаанд оролцсон малчид малын тоо толгойн хувьд 28,9 хувь нь 200 хүртэл толгой малтай, 35,8 хувь нь 201-500 хүртэл толгой малтай, 24,4 хувь нь 501-999 хүртэлх толгой малтай 1000 дээш толгой малтай иргэд 113 буюу 10.9 хувьтай байна.


Судалгаанд оролцсон малчдаас “Танд туслах малчин бий юу?” гэсэн асуултад 982 малчны 133 буюу 12.8 хувь нь туслах малчинтай гэсэн хариулт өгсөн бол 811 нь байхгүй, 38 буюу 3.7 хувь нь туслах малчинтай байсан одоо байхгүй гэсэн хариулт өгчээ.

График 45. Туслах малчинтай эсэх




“Туслах малчинтай эсэх?” гэсэн асуултыг малын тоо толгой харьцуулан үзэхэд туслах малчин ажиллуулж буй гэж хариулсан 133 хүний 86 нь туслах малчинтай байсан гэж хариулсан 38 хүний 30 нь 500 дээш малтай байна.

График 46. Туслах малчинтай эсэх, малын тоо толгойгоор




Хэрвээ та туслах малчинтай болох бол түүнийг ямар шалгуураар сонгож авах вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 29.4 хувь нь мал маллаж байсан туршлагатай, 20.1 хувь нь мал, өмчид өөриймсөг ханддаг гэсэн шалгуурыг голчлон үзнэ гэсэн байна.

График 47. Туслах малчинтай болох бол түүнийг ямар шалгуураар сонгож авах вэ?




Мөн туслах малчныг сонгоход ямар хүчин зүйл нөлөөлөх вэ? Гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 48.5 хувь нь нэг нутаг усны хүн байвал сайн гэж хариулсан бол нэг нутгийн хүн, садан төрлийн хүн, өөр сумын хүн байх нь нөлөөлөхгүй гэж 28.2 хувь нь хариулжээ.

График 48. Туслах малчин сонгоход нөлөөлөх хүчин зүйл




Судалгаанд оролцсон малчдаас танай өрхөд ямар хэрэгцээ шаардлага байгааг тодруулахад 33 хувь нь малжуулах арга хэмжээ гэсэн бол 32 хувь нь туршлага судлах сур 17.6 хувь нь туслах малчны хэрэгцээ шаардлага байна гэсэн хариултыг өгчээ. Малжуулах арга хэмжээ шаардлагатай байна гэж 200 хүртэл малтай иргэдийн дийлэнх нь хариулсан бол 201-500 малтай иргэдэд туршлага судлах хэрэгцээ шаардлага илүүтэй байна, 500 дээш малтай иргэд туслах малчны хэрэгцээ шаардлага байна гэсэн хариултыг өгчээ.

График 49. Малчин өрхөд тулгарч буй хэрэгцээ шаардлага.



Танд сургалт, мэдээллийн хэрэгцээ шаардлага байгаа бол ямар чиглэлийн сургалт хэрэгтэй байна гэсэн асуултад судалгаанд оролцогчийн 55.5 хувь нь малаас гарах түүхий эд боловсруулах чиглэлээр сургалт мэдээлэл хэрэгтэй гэсэн хариултыг өгчээ.

График 50. Танд сургалт, мэдээллийн хэрэгцээ шаардлага байгаа бол ямар чиглэлийн сургалт хэрэгтэй байна?



ГУРАВ: ДҮГНЭЛТ

Үндэсний статистикийн хорооноос гаргасан тооцооллоор Хөвсгөл аймгийн хүн ам 2025 онд 142173, 2030 онд 148422 болж өсөхөөр байна. Мөн энэхүү тооцооллоор 2025 онд хөдөлмөрийн насны хүн амын тоо 114214 болохоор байгаа бөгөөд хүн ам, ажиллах хүчний өсөлттэй холбоотойгоор хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлсан бодлого дэвшүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх оновчтой, арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Өнөөдрийн байдлаар статистик үзүүлэлтээр Хөвсгөл аймагт ажиллах хүч 55 мянга, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 37 мянга байгаа бол хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлээгүй 8 мянга гаруй хүн ам бодитойгоор байна хэмээн дүгнэж болохоор байгаа юм.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 40 хувийг шат шатны боловсролын байгууллагад суралцаж байгаа залуус эзэлж байгаа бөгөөд үүний 9000 гаруй нь ерөнхий боловсролын сургуульд, 6 мянга орчим нь Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-д суралцаж байна. Аймгийн хэмжээнд 15-24 насны 20 гаруй мянган залуу байгаагаас 4 хүн тутмын 3 нь шат шатны боловсролын байгууллагад суралцаж, ажиллах хүчнээс гадуурх хүн амд орж байгаа бол 25 хувь нь буюу 4 хүн тутмын 1 нь ажиллах хүчинд хамаарч байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 89 хувь нь цаашид их, дээд сургуульд дэвшин суралцахаар шийдсэн бөгөөд тэдний 75 хувь нь суралцах мэргэжлээ сонгожээ. Судалгаанд оролцсон сурагчдаас их, дээд сургууль, коллеж МСҮТ-д хаана суралцах талаар асуухад 71 хувь нь Улаанбаатар хотод гэсэн бол орон нутагтаа ажиллаж амьдарна хэмээн 4.4 хувь нь буюу нийт судалгаанд оролцсон 2147 хүүхдийн 85 хариулсан байна.

Их, дээд сургуульд суралцагчид ажлын байр хомс, цалин бага, дэд бүтэц муу, хувь хүний хөгжих боломж бага гэсэн шалтгаанаар 70 хувь нь аймаг орон нутагтаа ирж ажиллах сонирхолгүй байгаа байгаа бол 25.6 хувь аймгийн төв Мөрөн суманд, 6 хувь өөрийн үндсэн харьяаллын сум орон нутагтаа амьдарна гэсэн байна. Тухайлбал, Мөрөн сумын үндсэн харьяалалтай 231 оюутан судалгаанд оролцсоны 33.8 хувь Мөрөн сумандаа ирж ажиллаж амьдрах хүсэлтэй гэсэн бол Улаан-Уул сумын үндсэн харьяалалтай 22 оюутны нэг нь ч өөрийн сумандаа амьдарна гэсэн хариултыг сонгоогүй.

Судалгаанаас дүгнэхэд ажиллах хүчнээс гадуурх хүн амын 40 хувийг эзэлж байгаа ажиллах хүчийг ээлбэж байх ёстой үндсэн бүтэц болсон шат шатны боловсролын байгууллагад суралцагч 15 мянган хүн нь аймаг орон нутагтаа ажиллаж амьдрах сонирхолгүй байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтэд муугаар нөлөөлж, ажиллах хүчний хомсдолд оруулж байгаа үндсэн шалтгаан болж байна.

Нөгөө талаар аймаг орон нутагт дээд боловсролтой ажилчны эрэлт ханасан тул шинээр төгсөж ирсэн мэргэжилтнүүдэд ажлын байр хомс байгаа нь дээд боловсролтой ажилгүйчүүдийн хүрээг тэлж, тэднийг Хөвсгөл аймагт ажиллаж амьдрах хүсэл сонирхлыг бууруулж байгаа байдал ажиглагдаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн жил жилийн төгсөлт, их дээд сургуулийн элсэлтийн тоо мэдээнээс үзэхэд энэ нөхцөл байдал нь зөвхөн одоо үүсэж буй нөхцөл байдал биш бөгөөд сүүлийн 15 жилийн хугацаанд бий болсон цаашид ч мөн үргэлжилсээр байх тул сурагчдыг ажил мэргэжилтэй танилцуулах, тэдний хөдөлмөр эрхлэх сонирхол хүслийг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээ авах, оюутнуудад тохирсон цагийн ажлын тогтолцоог бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Суралцаж буй оюутнуудын эзэмшиж буй мэргэжилд дүн шинжилгээ хийхэд эрх зүй, анагаах ухаан, эдийн засаг, санхүү, багш, инженерийн чиглэлээр хамгийн олон оюутан суралцаж байгаа бол Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид ч мөн дээрх чиглэл, мэргэжлүүдээр сонгон суралцана гэж судалгаанд өндөр хувиар хариулжээ. Цаашид эдгээр мэргэжлийн эрэлт хэрэгцээг нарийвчлан судалж, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчид руу анхаарч ажиллах шаардлага гарч байна.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг сүүлийн 6 жилд суралцаж төгссөн 1235 төгсөгчийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд төгсөгчдийн 95 хувь, 2021-2022 оны хичээлийн жилд суралцаж буй 567 суралцагчийн 93.6 хувь нь Хөвсгөл аймгийн үндсэн харьяалалтай иргэн байна. Суралцаж төгссөн болон одоо суралцаж буй иргэдийг сумдын харьяаллаар авч үзэхэд Мөрөн, Төмөрбулаг, Цагаан-Уул, Түнэл, Бүрэнтогтох, Арбулаг сумдаас суралцагчийн тоо өндөр, Тариалан, Ханх, Цагааннуур сумдаас харьцангуй бага тоогоор элсэн суралцаж, төгсжээ.

Төгсөгчдийг эзэмшсэн мэргэжлээр авч үзэхэд оёдолчин, автомашин засварчин, барилгын сантехникч, тогооч, ойжуулагч, үсчин, гагнуурчин зэрэг мэргэжлүүдээр хамгийн олон мэргэжилтэн хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэн гарчээ.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдөөс авсан судалгаагаар төгсөгчдийн 62 хувь нь ажил эрхэлж байгаа бөгөөд үүний 40 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа бол тэдний 60 хувь нь мэргэжлийн бус ажил хийж байна. Ажил эрхлэхгүй байгаа шалтгааны дийлэнх хувь нь үргэлжлүүлэн сурч байгаатай холбоотой байна. Барилгын салбар болон оёдлын мэргэжлээр төгссөн төгсөгчдийн олонх нь мэргэжлээрээ ажиллаж байгаа бол ойн салбарыг төгссөн 21 хүн судалгаанд хамрагдахад зөвхөн 1 нь л мэргэжлээрээ ажиллаж байна.

2021-2022 оны хичээлийн жилд нийт 21 чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа бөгөөд үүнээс тогооч, засварчин, оёдолчин, барилгын засал чимэглэлч, сантехникч, гоо засалч, үсчин, цахилгаанчин, гагнуурчин зэрэг мэргэжлүүдээр хамгийн олон элсэгч суралцаж байна.

МСҮТ-д суралцаж байгаа иргэдийн 50 гаруй хувийг хамруулсан санал асуулгын судалгаанд суралцагчийн 59 хувь төгсөөд мэргэжлээрээ ажиллана гэж хариулсан бол 20 гаруй хувь нь цаашид үргэлжлүүлэн сурна гэжээ. Хаана ажиллаж амьдрах талаар асуухад 48 хувь нь Мөрөн суманд, 27.5 хувь нь Улаанбаатар хотод, 6.6 хувь нь сум орон нутагтаа ажиллаж амьдарна гэж хариулсан байна. Нийт суралцагчдын 44 хувь нь өөрөө өөртөө ажлын байр бий болгож хувиараа хөдөлмөр эрхэлж ажиллана гэсэн бол 27.3 хувь нь хувийн хэвшлийн аж ахуй нэгжид ажилд орно хэмээн хариулжээ.

МСҮТ-ийн бэлтгэж буй мэргэжлүүд аймгийн хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй байгаа ч суралцагчийн тоо эрэлтээс бага мөн төгсөгчид цаашид үргэлжүүлэн сурах, Улаанбаатар хотод ажиллаж амьдрах, хувиараа хөдөлмөр эрхлэх зэрэг хүсэл сонирхлоос шалтгаалан энэхүү эрэлт төдийлөн хангагдаж чадахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Тиймээс МСҮТ-ийн сургалтын чиглэл, үйл ажиллагааг хувийн хэвшлийн хүний нөөцийн хэрэгцээ шаардлага бодлоготой уях, элсэгчдийг мэргэжил, тоо хэмжээг гаргахдаа хувийн хэвшлийн захиалга судалгаан дээр үндэслэх цаашлаад элсэгчдийг сургуулиа төгсөхөд ажлын байранд шууд зуучлахын тулд тухайн мэргэжлийн чиглэлээр аж ахуй нэгжид суралцах хугацаанд нь ажлын байранд дадлага эзэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн үндсэн мэдээлэл, түүврийн аргаар зохион байгуулсан санал асуулгын судалгаа, цахим орчинд байршуулсан ажлын байрны зард хийх шинжилгээ, ажлын байр зарласан аж ахуй нэгжүүдээс телефон асуулгын болон цахим санал асуулгын аргаар судаллаа.

Аймгийн хэмжээнд 2600 орчим аж ахуй нэгж бүртгэлтэйгээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 1600 орчим байгууллага байна гэсэн статистик тоо мэдээ байна. Татвар, Нийгмийн даатгалын хэлтэст бүртгэлтэй, идэвхтэй харилцагч хувийн хэвшлийн байгууллага аж ахуй нэгж 1800 гаруй байгаа бөгөөд эдгээр аж ахуйн нэгжийн мэдээллийн сангаас үзэхэд 5300 иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн зах зээлд хамгийн олон хүн байнгын ажлын байраар хангаж ажиллаж байгаа аж ахуй нэгжүүдэд Хөвсгөл Дулаан, Хөвсгөл Эрчим хүч, Хөвсгөл Ус Суваг зэрэг төрийн болон орон нутгийн өмчит компаниуд, ХААН банк, Төрийн банк зэрэг үндэсний хэмжээний сүлжээ байгууллагууд байгаа бол түүний дараа хүнсний үйлдвэрүүд, худалдааны байгууллага орж байна.

Хамгийн олон хүнд ажлын байр олгож байгаа байгууллагуудыг эрэмбэлж үзэхэд эхний 50 байгууллагад 5300 орчим ажилтны 50 хувь нь ажиллаж байна.

Ажлын байрны заруудад дүн шинжилгээ хийж үзэхэд сүүлийн 3 сарын хугацаанд давтагдсан тоогоор 500 гаруй зар цахим орчинд зарлагджээ. Энэхүү ажлын байрны 71.3 хувь нь байнгын ажлын зар байгаа бол 77.6 хувь нь шинээр авах ажилтандаа ямар нэг боловсролын шаардлага тавиагүй байна, 78 хувь нь аж ахуй нэгж байгууллагад ажилд авах зар байсан бөгөөд худалдаа, үйлчилгээний чиглэлээр зарлагдсан ажлын байр нийт ажлын байрны 50 гаруй хувийг нь эзэлж байна.

Ажлын зар тавьсан аж ахуй нэгжээс судалгаа авахад судалгаанд хамрагдсан ажил олгогчоос 109 аж ахуй нэгж нийт 1360 иргэнийг ажлын байраар ханган үйл ажиллагаа явуулж байгаа цаашид ажилтан авах нэн шаардлагатай 224 шинэ ажлын байр байна гэсэн хариултыг өгчээ.

Үүнээс дүгнэхэд татвар, нийгмийн даатгалын мэдээллийн сангаас авсан мэдээллээр аймгийн хэмжээнд нийт аж ахуй нэгж 5300 ажилтан ажиллуулж байгаа гэсэн ч бодит байдалд түүнээс олон иргэн ажиллаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

2021 онд Үндэсний статистикийн хорооноос аж ахуй нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн улсын тооллого зохион байгуулсан. Энэхүү тооллогод хамрагдсан 2700 гаруй аж ахуй нэгжийн судалгаанд үндэслэн ажилтан албан хаагчдын бүртгэл мэдээллийг чанаржуулан хөдөлмөрийн салбарын бодлого, үйл ажиллагаанд ашиглах шаардлага байна.

Ажил олгогчид шинээр ажилтан авахдаа тууштай байдал, хувийн зохион байгуулалт, ажлын ачаалал даах чадвар, харилцаа хандлага, багаар ажиллах чадвар зэрэг тухайн хувь хүний хандлагыг гол шалгуураа болгож мэдлэг, боловсролыг хамгийн сүүлд эрэмбэлж байна.

Харин ажилгүй иргэдээс авсан судалгаанд оролцогчид ажилд орж чаддаггүй шалтгаанаа мэргэжил боловсролгүй, мэргэжилд тохирох ажлын байр байхгүй, амьдарч буй газар ажлын байр хомс гэх зэргээр тайлбарласан бол 40 дээш насныхан насны ялгаварлалтаас болж ажил олдохгүй байна гэжээ. Мөн ажилд ороход ямар ур чадвар хандлага дутагдаж байна гэсэн асуултад мэргэжлийн суурь мэдлэг, мэргэжлийн ур чадвар компьютер, гадаад хэлний мэдлэг зэрэг мэргэжил боловсролтой холбоотой мэдлэг ур чадваруудыг хамгийн ихээр нэрлэж байгаа бол ажил олгогч нарын хүссэн харилцаа хандлага, багаар ажиллах чадвар зэрэг ур чадвар хандлагыг хамгийн бага нэрлэсэн байна.

Энэ нөхцөл байдал нь ажил олгогч болон ажилгүй иргэдийн хүсэл сонирхол огтлолцохгүй байгаагийн дээр иргэдийн дунд хувийн хэвшилд ажиллахаас илүү төрийн албанд ажиллах хүсэл сонирхол илүүтэй байна. Тухайлбал оюутнуудаас авсан санал асуулгын судалгаанд төгсөөд 70 хувь нь төрийн албанд ажиллах хүсэл сонирхолтой гэж хариулсан байна.

Аймгийн хэмжээнд төрийн албанд 7171 хүн ажиллаж байгаагийн дийлэнх хувь нь боловсрол, эрүүл мэндийн салбар буюу төрийн үйлчилгээний салбарт ажиллаж байна. Их дээд сургуульд суралцагчдыг мэргэжлээр жагсааж үзэхэд эрүүл мэнд болон боловсролын чиглэлээр суралцаж байгаа оюутны тоо өндөр байгаа бөгөөд боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллах хүчний нийлүүлэлт хангалттай байна.

2019 оноос хойш 4 удаа зохион байгуулагдсан төрийн албаны ерөнхий шалгалтад давтагдсан тоогоор 2102 гаруй иргэн шалгалт өгсөн бөгөөд 479 иргэн шалгалтад тэнцэн төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн байгаа нь төрийн захиргааны ангилалд ажиллах хүний нөөц хангалттай байгааг илтгэж байна.

Аймгийн хэмжээнд өөрөө өөртөө ажлын байр бий болгон ажиллаж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоон мэдээг авч үзэхэд 2021 онд 1677 хувиараа хөдөлмөр эрхлэгч тоолуулжээ. Судалгааны хүрээнд хувиараа хүн ам амын орлогын албан татвар төлж байгаа иргэдийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийж үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэн ангилж үзэхэд дийлэнх хувийг нь буюу 67.2 хувийг хүнс барааны дэлгүүр лангуу ажиллуулж байгаа иргэд эзэлж байна.

Судалгаанаас дүгнэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгчийг аж ахуйн нэгж болон өргөжиж үйл ажиллагаагаа тэлэх өндөр сонирхолтой байгаа бөгөөд үүнд чиглэсэн сургалт мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, тэдэнд тохирсон татварын уян хатан бодлого дэвшүүлэх, зах зээлийн багтаамжийг нь тэлэх зорилгоор бодлого дэвшүүлж, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

Мөн 2021 оны эцэст зохион байгуулагдаж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчийн улсын тооллогын мэдээллийн санд дүн шинжилгээ хийж тэдний шинээр бий болгож буй ажлын байрны хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, албан бус хөдөлмөр эрхлэлтийг судалгааг аймгийн хэмжээнд хийж дүгнэлт, санал зөвлөмж гарган үйл ажиллагаанд тусган ажиллах хэрэгтэй байна.

Хөвсгөл аймгийн ажиллах хүчний 50 гаруй хувийг хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мал аж ахуйн салбар эзэлж байна. Малчин өрх болон мал бүхий өрхийн тоо 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 2246-гаар өссөн бол малчдын тоо буурах хандлагатай байгаа бөгөөд аймгийн 10 суманд малчдын тоо 5 жилийн өмнөхөөс буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 500-1000 хүртэл толгой малтай өрх 2562, 1000 дээш малтай өрх 622 байгаа бөгөөд судалгаагаар 500-1000 толгой малтай өрхийн 17 хувь нь, 1000 дээш малтай өрхийн 43.3 хувь нь туслах малчин ажиллуулж байна.

Малчин өрхийн хэрэгцээ шаардлагыг судалж үзэхэд 200 хүртэл малтай өрхийн дийлэнх нь малжуулах хэрэгцээ шаардлагатай байна гэж хариулсан 201-500 хүртэл малтай өрх туршлага судлах хэрэгцээ шаардлагатай байна, 500 дээш малтай өрх туслах малчны хэрэгцээ шаардлага байна гэж хариулсан байна.

Мөн судалгаанд оролцсон малчдын 25 хувь нь ирэх жилүүдэд туслах малчин авч ажиллуулах хэрэгцээ шаардлага байна. 55 хувь нь малаас гарах түүхий эдийг боловсруулан зах зээлд нийлүүлэх талаар сургалт мэдээлэл хэрэгтэй байна гэсэн бол 17 хувь нь мал маллахаас гадна өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэл сонирхол байна гэсэн хариултыг сонгожээ.

Малчдын тоо буурахын зэрэгцээгээр туслах малчны хэрэгцээ шаардлага өсөж байгаа бөгөөд ажлын зард хийсэн дүн шинжилгээгээр ч энэхүү нөхцөл байдал ажиглагдаж байна. Цаашид туслах малчныг бэлтгэх энэ салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

ДӨРӨВ: САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр нэгдсэн бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөлт дутагдаж байна. Үүнд: Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний дийлэнх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв, түүний үйл ажиллагааны чиглэлүүдээр дүгнэгдэж байгаа нь тухайн салбарын асуудлыг явцуу байдлаар харахад хүргэж байна.

Тиймээс холбогдох хууль тогтоомжид үндэслэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэрийг хангах зорилгоор Хөвсгөл аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулан баталж түүгээр дамжуулан салбар дундын болон засаг захиргааны нэгжийн уялдаа холбоог ханган ажиллах шаардлагатай байна.

2. Хөдөлмөр эрхлэлтийг салбарт дэвшүүлж буй бодлого, зорилт, арга хэмжээг оролцогч талуудын анхааралд хүргэх, тухайн салбарт зохион байгуулагдаж буй ажлын цар хүрээг тэлэх, чанаржуулах, ач холбогдлыг сайжруулах, төсөв санхүүг шийдвэрлэх зорилгоор аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарлаж нэгдсэн удирдамжаар хангаж шат шатны арга хэмжээг зохион байгуулах хэрэгцээ байна.

3. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын тоо мэдээнд үндэслэн хөдөлмөр зуучийн үйлчилгээг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгоор ажил идэвхтэй хайгчийг олж бүртгэлжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлагдаж байгаа ажлын байрны мэдээлэл болон аймагт шинээр хийгдэж буй бүтээн байгуулалтад шаардлагатай ажиллах хүчний судалгаа, шинээр бий болох ажлын байрны бүртгэлийг тогтмолжуулах замаар ажилд зуучлах үйлчилгээг чанаржуулах шаардлагатай байна.

4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын их, дээд сургуульд дэвшин суралцах сонирхол, их дээд сургуульд суралцаж буй оюутнуудын төрийн байгууллагад ажилд орох хүсэл эрмэлзэл, төгсөөд Улаанбаатар хот болон гадаад улс орон, бусад газар ажиллаж амьдрах зорилгоос шалтгаалан Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтэд эрсдэл гарч байна. Иймээс шат шатны боловсролын байгууллагад суралцаж буй суралцагчийн мэргэжил сонголтод нөлөөлөх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг багш, эцэг эх, сургуулийн удирдлага, сум орон нутгийн удирдлагын түвшинд анхааран хамтын ажиллагаагаа дээшлүүлэх нь зүйтэй.

5. Их дээд сургуульд элсэгчид, төгсөгчдийн бүртгэл мэдээллийн тогтолцоог сайжруулах, оюутнуудын орон нутагтаа ажиллаж, амьдрах хүсэл сонирхлыг төрүүлэхүйц тодорхой арга хэмжээг зохион байгуулж хэвших, төгсөгчид орон нутагт ажлын байр хомс гэсэн шалтгаанаар ирж ажиллах сонирхолгүй байгааг харгалзан ажлын байрны мэдээллийг суралцаж байх хугацаанд нь хүргэж байх хэрэгтэй байна.

6. Хөвсгөл аймгийн ажиллах хүчний 50 гаруй хувийг эзэлж байгаа хөдөө аж ахуйн салбар тэр дундаа малчид руу чиглэсэн туслах малчин, туслах ажилтны ажлын байрыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа зохион байгуулах хэрэгцээ шаардлага судалгааны дүнгээс харагдаж байна. Тодруулбал: 500 дээш толгой малтай малчдын туслах малчны хэрэгцээ шаардлагыг орон нутгийн засаг захиргааны нэгжээр дамжуулан судалж шаардлагатай ажиллах хүчийг богино хугацааны сургалтаар чадавхжуулан хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх, малчдын өрхийн үйлдвэрлэл болох сүү цагаан идээг зах зээлд борлуулах нэгдсэн кластерийн систем хөгжүүлж мал аж ахуйн салбарт туслах ажилтны эрэлтийг бий болгох гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлж болохоор байна.

7. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын чиглэл, мэргэжлийг орон нутгийн хувийн хэвшил, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлдэх, суралцаж байх хугацаанд нь захиалгын ажлын байранд нь дадлага туршлага эзэмшүүлэн, төгсөхөд нь тухайн аж ахуй нэгж, ажлын байранд шууд зуучлах тогтолцоог бий болгох нь эрэлт нийлүүлэлтийг орон нутагтаа хангах, дунд шатны ажилчдын хомсдол байдлыг арилгах ач холбогдолтой

8. Хувийн хэвшил, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийн санд тулгуурлан албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэлжүүлж тухайн салбарт ажиллаж байгаа иргэдийг сургалтад хамруулан ажлын байранд нь тогтвортой ажиллуулах бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

9. Аймгийн хэмжээнд 300-гаас дээш ажилтантай хувийн хэвшлийн аж ахуй нэгж байхгүй байгаад анхааран ажиллах хүчийг шингээх томоохон аж ахуй нэгжийг байгуулах чиглэлээр бодлого барьж ажиллах шаардлагатай байна.

ТАВ: ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хөдөлмөр эрхлэлтийн бүдүүвч /23 сум/

Хавсралт 2. Их, дээд сургуульд суралцаж буй оюутнууд мэргэжил, курсээр /23 сум/

Хавсралт 3. Ашигласан материал, ном зүй

Хавсралт 4. Үндсэн ойлголтын тайлбар

ХАВСРАЛТ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БҮДҮҮВЧ /23 СУМ/

Хүснэгт 50. Мөрөн сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	15245	13658	1587	12618	4549	3218	774	1247	2160	60	610
1-р баг	1196	1125	71	1206	334	404	86	109	42	5	226
2-р баг	940	858	82	669	240	211	56	92	59	0	11
3-р баг	1071	952	119	821	346	233	51	65	109	6	11
4-р баг	1006	950	56	990	340	251	59	75	245	0	20
5-р баг	785	720	65	841	266	201	45	74	163	1	91
6-р баг	1017	974	43	746	263	229	36	57	139	2	20
7-р баг	1532	1345	187	1004	363	290	88	111	113	2	37
8-р баг	1036	1012	24	659	220	231	29	70	90	11	8
9-р баг	1140	993	147	1040	385	206	47	126	236	4	36
10-р баг	1126	966	160	940	337	174	37	75	251	7	59
11-р баг	864	757	107	910	317	196	79	68	232	5	13
12-р баг	986	880	106	619	307	170	36	40	51	0	15
13-р баг	1399	1164	235	1232	470	235	62	183	229	16	37
14-р баг	1147	962	185	941	361	187	63	102	201	1	26

Хүснэгт 51. Алаг-Эрдэнэ сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	2795	2674	121	1826	673	458	103	88	395	2	107
1-р баг, Шувуут	341	335	6	129	71	28	7	4	9	1	9
2-р баг, Ужиг /Цагаан бэлчир/	331	329	2	180	86	50	9	0	18	0	17
3-р баг, Яргис	184	182	2	82	55	6	3	2	11	1	4
4-р баг, Цагаан бургас	219	218	1	91	32	43	4	8	3	0	1
5-р баг, Манхан	320	318	2	353	107	89	14	1	139	0	3
Хатгал тосгон	1400	1292	108	991	322	242	66	73	215	0	73

Хүснэгт 52. Арбулаг сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	1850	1814	36	835	405	175	31	38	73	1	112
1-р баг, Хавтага	308	306	2	129	54	17	6	9	37	0	6
2-р баг, Бор гол	356	354	2	111	44	38	3	4	4	0	18
3-р баг, Бэл булаг	368	365	3	94	71	16	0	0	1	1	5
4-р баг, Сүмбэр	245	238	7	138	88	23	7	3	15	0	2
5-р баг, Тарган нуур	238	221	17	252	75	63	10	15	10	0	79
6-р баг, Урт булаг	335	330	5	111	73	18	5	7	6	0	2

Хүснэгт 53. Баянзүрх сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	1899	1873	26	747	355	175	58	65	69	6	19
1-р баг, Эмг	453	450	3	110	79	21	4	2	2	0	2
2-р баг, Хайс	434	432	2	192	97	34	23	20	13	2	3
3-р баг, Тоом	332	328	4	126	79	19	11	5	5	0	7
4-р баг, Агар	375	374	1	89	33	24	7	10	11	3	1
5-р баг, Бэлгэс	305	289	16	230	67	77	13	28	38	1	6

Хүснэгт 54. Бүрэнтогтох сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	1952	1920	32	1015	405	338	59	31	159	4	19
1-р баг, Сангийн далай	374	373	1	97	67	19	5	0	1	2	3
2-р баг, Бүрэнхаан	454	451	3	191	98	69	8	6	6	0	4
3-р баг, Их уул	394	391	3	314	99	101	20	5	85	0	4
4-р баг, Баянхошуу	254	235	19	213	71	79	7	9	45	1	1
5-р баг, Туяа	206	204	2	89	26	40	12	7	1	0	3
6-р баг, Эрчим	270	266	4	111	44	30	7	4	21	1	4

Хүснэгт 55. Галт сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	2400	2385	15	1303	709	281	50	71	159	2	31
1-р баг, Нүхт	568	564	4	176	152	8	7	3	2	1	3
2-р баг, Зүрх	591	591	0	305	155	73	15	8	44	0	10
3-р баг, Рашаант	530	528	2	274	161	86	6	6	6	1	8
4-р баг, Хужирт	434	431	3	172	111	33	6	8	6	0	8
5-р баг, Галт	277	271	6	376	130	81	16	46	101	0	2

Хүснэгт 56. Жаргалант сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	2195	2178	17	1591	707	296	71	228	252	7	30
1-р баг, Хөнжил	481	479	2	329	148	51	20	63	44	1	2
2-р баг, Цэцүүх	520	516	4	320	165	70	12	17	35	4	17
3-р баг, Цагаан бургас	471	469	2	295	162	39	9	67	16	0	2
4-р баг, Харгана	205	205	0	173	68	41	8	25	22	2	7
5-р баг, Оргил	518	509	9	474	164	95	22	56	135	0	2

Хүснэгт 57. Их-Уул сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	1856	1830	26	1001	440	312	64	29	98	0	58
1-р баг, Шивээ	528	522	6	253	133	79	15	8	10	0	8
2-р баг, Их-уул	257	257	0	98	46	33	4	1	5	0	9
3-р баг, Асгат	306	306	0	126	47	33	13	1	4	0	28
4-р баг, Мандал	325	323	2	156	74	39	19	6	10	0	8
5-р баг, Сэлэнгэ	440	422	18	368	140	128	13	13	69	0	5

Хүснэгт 58. Рашаант сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
Бүгд	1618	1572	46	994	447	235	46	99	135	1	31
1-р баг, Тээл	292	287	5	111	48	41	5	5	4	1	7
2-р баг, Талын ус	412	411	1	160	101	28	1	19	2	0	9
3-р баг, Энх тал	245	245	0	137	47	28	3	28	24	0	7
4-р баг, Цэнгэл	305	278	27	372	119	93	26	39	94	0	1
5-р баг, Их ац	364	351	13	214	132	45	11	8	11	0	7

Хүснэгт 59. Рэнчинлхүмбэ сумын хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийн бүдүүвч

	Ажиллах хүч			Ажиллах хүчнээс гадуурх хүн ам							
	Бүгд	Ажил эрхэлдэг	Ажил хайж байгаа	Бүгд	Сургуульд сурдаг	Тэтгэвэрт	Хөдөлмөр эрхлэх чадваргүй	Гэрийн ажилтай	Тохирох ажил олдохгүй байгаа	Ажиллах сонирхолгүй	Бусад
